



Inter-Parliamentary Union
For democracy. For everyone.



ПАРЛАМЕНТ БА ХҮНИЙ ЭРХ

**Өөрийн үнэлгээний
аргачлал**

Энэ хэвлэлийн эх хувийг Олон Улсын Парламентын Холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллага (Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын нэрийн өмнөөс) хамтран хэвлүүлсэн.

Энэ хэвлэлд орсон тэмдэглэл, материалууд нь Олон Улсын Парламентын Холбооны зүгээс аливаа улс орон, газар нутаг, хот, бүс нутаг эсхүл тэдгээрийн эрх баригчдын хууль эрх зүйн болон хөгжлийн нөхцөл байдал, хил хязгаараар ялган ангилахтай холбоотой аливаа үзэл бодол агуулаагүй болно. Тодорхой компани, үйлдвэрлэгчийн патенттай болон патентгүй бүтээгдэхүүний талаар энд дурдсан байвал бусдаас онцлон эдгээрийг сонгосон, ийм шалтгаанаар бусдыг дурдахгүй байхыг ОУПХ-ноос санал болгосон, зөвшөөрсөн гэсэн үг биш юм.

Энд илэрхийлсэн агуулга нь гагцхүү зохиогчдын байр суурь, үзэл бодол бөгөөд ОУПХ, НҮБХЭДКГ-ын байр суурийг илэрхийлэхгүй.

ISBN: 978-92-9142-896-0

© Олон Улсын Парламентын Холбоо, 2022

ОУПХ нь энэ аргачлал дахь мэдээлэл, материалыг ашиглах, дахин боловсруулах, түгээхийг дэмжинэ. Өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд, энэ хэвлэлийн аливаа хэсгийг хувийн судалгаа, заах, сургах зорилгоор хуулбарлах, хуулах, хэвлэж болох ба зохиогчийн эрх, эх сурвалжийг ОУПХ, НҮБХЭДКГ хэмээн зохих ёсоор дурдсан тохиолдолд ашгийн төлөө бус зорилгоор мөн ямарваа нэг өөрчлөлт оруулалгүйгээр ОУПХ болон НҮБХЭДКГ-аас хэрэглэгчдийн үзэл бодол, бүтээгдэхүүн, үйлчилгээнд ямар нэг байдлаар холбохгүйгээр ашиглаж болно.

Хэвлэлийг ашиглаж буй талаар Олон Улсын Парламентын Холбоо (press@ipu.org)-нд мэдээлнэ үү.

Орчуулсан:	Б.Хангалсайхан
Хянан тохиолдуулсан:	Г.Агар-Эрдэнэ, С.Алтанхуяг
Дизайн:	А.Чинбат

Монгол хэл дээрх хэвлэл нь Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтарсан “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгүүлсэн албан бус орчуулга бөгөөд орчуулгын үнэн зөв байдал, түүнээс үүдсэн хариуцлагыг орчуулагч хариуцна.

“Хөх Монгол принтинг” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

Агуулга

Оршил	3
Хүний эрх гэж юу вэ?	5
Хүний эрхийг юу бий болгодог вэ?	5
Хүний үндсэн ямар эрх байдаг, тэдгээрийг хаанаас олж болох вэ?	8
Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилгууд	14
Улс орны хүний эрхийн чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд олон улсын хүний эрхийн ямар механизмууд хяналт тавьдаг вэ?	17
Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх Парламентын чиг үүрэг	22
Үндэсний түвшинд парламентын хүлээх үүрэг	22
Олон улсын хүний эрхийн механизмын үйл ажиллагаан дахь Парламентын оролцоо	30
Хүний эрхийн асуудлаар өөрийн үнэлгээ хийхэд бэлтгэх	33
Үнэлгээний зорилго ба хэрэглээ	33
Удирдлагын дэмжлэг	34
Тэгш хамруулах, гардан хариуцах	35
Өөрийн үнэлгээг зохион байгуулах	35
Өөрийн үнэлгээ хийсний дараа: хэрэгжүүлэх ба авах арга хэмжээ	35
Өөрийн үнэлгээний шалгах хуудас	36
Өөрийн үнэлгээний асуултууд	38
Асуулт 1: Парламентын түвшинд хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх	38
Асуулт 2: Хүний эрхийг дэмжих талаар хууль тогтоомж гаргаж байгаа юу?	40
Асуулт 3: Парламентын хяналтыг бэхжүүлэх	42
Асуулт 4: Парламентын үйл ажиллагаанд хүний эрхийн асуудлыг тусгах	44
Асуулт 5: Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх	46
Асуулт 6: Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилго 2030 хоорондын уялдааг хангах	49
Асуулт 7: Хүний эрхийг хангахад шаардлагатай санхүү, төсвийг баталгаажуулах	51
Асуулт 8: Олон нийт болон хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх	53
Ном зүй	55

Хүний эрхийг хүндэтгэх нь хүчтэй ардчилсан нийгмийн чухал суурь нь юм. Энэ суурь чухал болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг ч хүний эрх хангагдахгүй, хамгаалагдахгүй байх явдал дэлхий дахинд байсаар л байна. Олон улсын болон бүс нутгийн мөргөлдөөн, хүмүүнлэгийн хямрал, өсөн нэмэгдэж буй дарангуй дэглэм, арьс өнгөний үзэл, гадаад хүнийг ялгаварлах үзэл, уур амьсгалын өөрчлөлт, тэгш бус байдал, дэлхий дахиныг хамарсан цар тахал зэрэг нь асар том сорилтуудыг бий болгож, хүний эрхийн асуудлыг өөрсдийн ажлын гол төвд тавьж, хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэхийг улс орны парламентуудаас шаардах болов.

Парламент энэ талаар юу хийх боломжтой вэ? Парламент нь хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоомжийг батлах, хүний эрхийн гэрээ, конвенцийг соёрхон батлах, засгийн газрын хариуцлагыг сайжруулах, хүний эрхийг хангахад чиглэсэн төсөв батлах замаар хүний эрхийг хамгаалах үндэсний хэмжээний системийг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Парламент мөн хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон улсын болон дотоодын холбогдох талуудтай хамтран ажиллах, олон улсын хүний эрхийн стандартуудыг улс орны нөхцөлд нийцүүлэн шууд болон шууд бусаар дагаж мөрдүүлэх боломжтой.

Өөрийн үнэлгээний аргачлал нь парламентын хэмжээнд олон улсын хүний эрхийн стандарт, механизмыг хэр түвшинд мэдэж, парламентын үйл ажиллагаа, зарчим, бүтцэд хэрхэн тусгагдан хэрэгжиж буйд үнэлгээ хийх боломжийг парламентад олгоно. Дотоод нөхцөл байдлаа үнэлэх энэ дасгал нь парламентуудыг сайн туршлага, хийдэл, сургамжаа тодорхойлж, хүний эрхийн асуудалд илүү мэдрэмжтэй байж, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах боломжийг олгоно. Энэ аргачлал нь Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын газар (НҮБХЭДКГ)-аас хүний эрхийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэхэд парламентуудад дэмжлэг үзүүлдэг туршлагад суурилсан бөгөөд парламентыг өөрийн хөгжлийн эзэн байж, эрх мэдэлжүүлэх зорилготой Парламентад дэмжлэг үзүүлэх нийтлэг зарчмуудад нийцсэн юм. Түүнчлэн ОУПХ болон НҮБХЭДКГ-ын хамтран гаргасан Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага №26-д нэмэлт болох агуулгыг багтаасан.

Аргачлалыг улс төрийн системээс үл хамааран парламентын бүхий л гишүүд ашиглаж болохоор боловсруулсан. Түүнчлэн энэ аргачлал нь хүний эрх болон Тогтвортой хөгжлийн зорилгуудын хоорондын уялдаа холбоог хангах замаар олон улсын хүний эрхийн механизмын талаарх зөвлөмжүүдийг Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 2030-той уялдуулан хэрэгжүүлэхэд парламентуудад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Сайн дурын үндсэн дээр өөрийн үнэлгээ хийснээр парламентуудыг байр эзлүүлж, жагсаахыг зорьдоггүй. Парламент энэ аргачлалд санал болгож буй бүх асуултыг бүгдийг нь хэрэглэхгүй байж болох ба улс орныхоо онцлогт нийцүүлэн тохируулан хэрэглэхийг зөвлөдөг. Түүнчлэн, өөрийн үнэлгээний үр дүн нь хүний эрхийн хэм хэмжээ, механизмуудыг парламент үйл ажиллагаандаа хэрхэн тусгаж буйгаа бодитой харах болон хүний эрхийг хангах, хамгаалах талаар ахиц дэвшил гаргахын тулд үнэлгээний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрмэлзэл хэр байгаагаас шалтгаална. Иймээс, өөрийн үнэлгээг манлайлж оролцох нь парламентуудыг хүний эрхийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудаа биелүүлж, бүгдийг тэгш хамруулах нөхцөлийг ханган, хамтдаа ажиллах боломжтой болгоно.

Хүний эрх гэж юу вэ?

“Хумүүс – тэдний эрх – эн тэргүүнд гол төвд байх ёстой. Хүний эрхийн хандлага нь хүн бүрийг тэгш хамруулах, хэнийг ч хөгжлийн гадна үлдээхгүй байхыг хэлнэ.”

Антонио Гутеррес

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Нарийн бичгийн дарга, 2020¹

Хүний эрхийг юу бий болгодог вэ?

Хүний эрх, түүний түгээмэл, салшгүй, хуваагдашгүй болон харилцан хамааралтай байдлыг тодорхойлохын тулд тунхаглал, гэрээ, конвенц, тогтоол зэргийг боловсруулсан байдаг. Парламентын гишүүдийг хүний эрхийг хүндэлдэг, хамгаалдаг, хэрэгжүүлдэг байлгахын тулд хүний эрхийн стандарт болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрийн улсын хүлээсэн үүргийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байх нөхцлөөр тэднийг хангах шаардлагатай.

Зураг 1. Хүний эрхийн жишээ²

Иргэний болон улс төрийн эрхийн талаар

- Амьд явах салшгүй эрх
- Залхаан цээрлүүлэх, хэрцгий, хүнлэг бус хандах, хүний нэр төрийг гутаан доромжлох, шийтгэхээс ангид байх эрх
- Боолчлол, боолын худалдаа, албадан хөдөлмөрлүүлэхээс ангид байх эрх
- Хувь хүний эрх чөлөө, аюулгүй байдлаа хангуулах эрх
- Саатуулагдсан бүх хүнтэй хүнлэг байдлаар харьцахыг шаардах эрх
- Шударга шүүхээр шүүлгэх эрх
- Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох
- Хуулийн өмнө хүн ёсоор хандахыг шаардах эрх
- Хүний хувийн орон зайг хүндлэх эрх
- Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх эрх чөлөө
- Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө
- Дайныг сурталчилах, үндэсний үзэл, арьс өнгө болон шашны үзэн ядах үзлийг хориглох
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө
- Байгууллага байгуулах эрх чөлөө
- Гэр бүл болох, гэр бүлтэй байх эрх чөлөө
- Төрийн үйл хэрэгт оролцох, саналаа өгөх, сонгогдох, төрийн албанд орох эрх

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаар

- Ажил хөдөлмөр эрхлэх эрх
- Шударга, таатай нөхцөлд ажиллах эрх
- Үйлдвэрчний эвлэл байгуулах, түүнд элсэх эрх
- Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх
- Гэр бүлээ хамгаалах эрх
- Хангалттай хоол хүнс, хувцас, орон байр, ус, цэвэрлэх байгууламж зэргийг хангасан амьжиргааны зохистой түвшинг хангах эрх
- Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Сурч боловсрох эрх
- Өөрийгөө таньж мэдэх, тодорхойлох эрх
- Өөрийгөө хөгжүүлэх эрх
- Соёлын амьдралд оролцох эрх

1 НҮБХЭДКГ “Бид бүгд үүнд хамтдаа: НҮБ-ын ЕНБД “Ковид-19” ба Хүний эрх сэдвээр хэлсэн үг. 2020 оны 4-р сарын 23. <https://ohrh.org/en/stories/2020/04/we-are-all-together-ung-delivers-policy-brief-covid-19-and-human-rights>.

2 Хүний эрх, бусад нийтлэг эрх, хүний эрхийн суурийн талаар илүү мэдээллийг ОУПХ, НҮБХЭДКГ Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага №26 (Женев хот, ОУПХ, НҮБХЭДКГ, 2016) <https://www.ohrh.org/sites/default/files/Documents/Publications/HandbookParliamentarians.pdf>.

Эрх эдлэгч болон үүрэг гүйцэтгэгчдийн тухай ойлголт

Хүний эрх нь хувь хүмүүс (Эрх эдлэгч), төр улс, бусад эрх мэдлийн байгууллага (үүрэг гүйцэтгэгчид)-ийн хоорондын харилцааг тодорхойлно. Иймээс хувь хүмүүс нь засгийн газар, бусад эрх бүхий байгууллагыг хүний эрхийг хангах, хамгаалах талаар авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлээгүй арга хэмжээний талаар хариуцлага хүлээлгэдэг байлгахын үр шимийг голлон хүртэгсэд байна. Энэ утгаараа хариуцлага нь хүний эрхийн суурь зарчим байх бөгөөд бүх иргэд, тэр дундаа хамгийн эмзэг бүлгийн иргэдийг төрийн бодлогын төвд байх нөхцөлийг хангахад тустай байдаг. Хүний эрхийн олон улсын хэм хэмжээний талаар хүлээсэн үүргээ төр хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих эрхтэй байдаг тул парламент энд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хүний эрх түгээмэл, салшгүй болох нь

Хүн бүр төрөлхөөс заяасан нэр төрөө хамгаалуулах эрхтэй байдаг. Хүн бүр арьс өнгө, жөндөр, шашин шүтлэг, хүйс, нийгмийн болон гарал угсаа, үндэс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад шинж байдлаас үл хамааран угаас заяасан эрхтэй байна.



Эдгээрийг улс орон, хүмүүс нийтлэг хүлээн зөвшөөрсөн байдаг тул хүний эрх нь хүн бүрт ижил тэгш, ялгаварлалгүйгээр хамаарна. Өөрөөр хэлбэл, шударга шүүхээр хэрэг нь шийдэгдэж шүүхээс гэм буруутайг нь нотлох зэрэг олон улсын эрх зүйгээр тодорхойлсон шалгуураар тодорхой эрхийг нь хассанаас бусад тохиолдолд хэнээс ч эрхийг нь салгаж болохгүй.

Хүний эрх хуваагдашгүй, харилцан хамааралтай болох нь

Хүний аль нэг эрхийг хангах нь нөгөө эрхэд нөлөөлдөг тул эрх бүр хоорондоо хамааралтай, бие даасан, хуваагдашгүй цогц байдлаар авч үзэх нь зүйтэй. Харилцан уялдаа бүхий хандлага нь аль нэг эрх нь нөгөөгөөсөө илүү чухал гэсэн ойлголтыг үгүйсгэж, хүний эрх адил тэгш болохыг илэрхийлдэг. Тухайлбал, амьд явах эрх нь хүний хоол хүнсээр хангагдах, амьжиргааны зохистой түвшинд байх эрхийг хангахтай хамаатай. Хүний сурч боловсрох үндсэн эрхийг үгүйсгэх нь төрийн үйл хэрэгт оролцох, шударга шүүхээр шүүлгэх эрхэд нөлөөлж болзошгүй. Эдийн засаг, нийгмийн эрхийг хангах нь үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар цуглаж, эвлэлдэн

нэгдэх эрхтэй хамаатай байна. Үүнтэй адилаар иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн эрх нь хувь хүний нэр төр, халдашгүй байдлыг хангахад ижил тэгш чухал үүрэгтэй байна. Түүнчлэн, хүний бүхий л эрхийг хүндлэх нь тогтвортой энх тайван байдал, хөгжлийн урьдач нөхцөл юм. Хүний эрх харилцан хамааралтай болох нь олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд системтэйгээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

Хүний эрх нь хоорондоо хамааралтай тул хүний эрхийн зөрчил ч мөн адил байна.

Хүний аль нэг эрхийг зөрчих нь нөгөө эрхийн зөрчилд мөн хүргэж байдаг тул хүний эрхийн зөрчил хоорондоо хамааралтай байна. Швейцарын Фрибургийн их сургуулийн Ёс зүй, хүний эрхийн салбар хоорондын институтын судлаачид “цогц халдвар”-ийн онолыг санал болгосон³. Хүний аль нэг эрхийг зөрчсөн, түүнийг хамгаалах талаар арга хэмжээ авахгүй байх нь цаашлаад бусад эрхийн зөрчил гарах эрсдлийг нэмэгдүүлэх ба хариуцлага тооцоогүй байх нөхцөлд ийм зөрчил дахин гарах нөхцөлийг бий болгодог.

Ижил тэгш, үл ялгаварлах зарчим

Ижил тэгш байх, үл ялгаварлах зарчим нь хүний эрхийн гол цөм бөгөөд маш олон шалтгаан, олон төрлийн сул талыг бууруулдаг. Хүний эрх нь тодорхой бүлэгт зориулагдсан бус, харин нийгмийн бүх хэсэг, энэ дэлхийн хүн бүрт хамаатай. Гэвч шашны, угсаатны болон үндэсний цөөнх, Африк гаралтай хүмүүс, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигч, ахмад настнууд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, ижил хүйстэн, бисексуал, трансжэндэр, бусдаас өөр бэлгийн чиг баримжаатай, интерсекс (LGBTQ+) хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт байсаар байна. “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын “хэнийг ч орхихгүй” байх хандлага нь ижил тэгш байх, үл ялгаварлах таатай нөхцөлийг бий болгож байна. Хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаа нь хүйс, арьс өнгө, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа болон нийгмийн гарал, үндэсний цөөнхийн гишүүн байх, өмч, төрөлт, нас, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, нийгмийн болон бусад статус зэргээр ялгаварлан гадуурхахтай үр дүнтэй тэмцэх ёстой.

3 Жоханне Боучард, Патрице Мэйер-Биш, “Хүний эрхийн олон талт, харилцан хамааралтай болох нь: Адил уу, ялгаатай юу”, Ижил тэгш эрхийн талаар <https://equalrightstrust.org/sites/default/files/ertdocs/Intersectionality%20and%20Interdependence%20of%20Human%20rights%20Same%20%20Different.pdf>

Хүний үндсэн ямар эрх байдаг, тэдгээрийг хаанаас олж болох вэ?

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

“Энэхүү Тунхаглалд тусгасан хүний эрхийн төгс байдал нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн бүтээлч бөгөөд хамгийн амжилттай дэвшлүүдийн нэг гэдэгт би итгэлтэй байна.”⁴

Мишель Бачелет

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссар, 2018

Дэлхийн I болон II дайны улмаас үүссэн харгислал нь хүний амьдралын үнэ цэн, харилцан бие биеэ хүндлэх хүн төрөлхтөний чадамжид үл итгэх байдлыг бий болгосон. Хүний нэр төрийн халдашгүй байдлыг хамгаалах, цус асгаруулсан хөнөөлт дайн дахин гарахаас сэргийлэх хүрээнд олон улсын хамтын нийгэмлэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм дэх “хүний эрх” гэсэн нэр томъёог анх удаа хүчтэй тусган заасан баримт бичгийг хамтран боловсруулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комисс бараг бүтэн хоёр жилийн дараа буюу 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хүний эрхийн Түгээмэл тунхаглалыг боловсруулж дуусчээ. Хэдийгээр энэ нь хууль ёсоор заавал дагаж мөрдөх шинжгүй боловч Тунхаглал нь одоо хүний эрхийн нийтлэг стандарт болж хэрэгжиж байна.

Эцэст нь, хүний эрх хаанаас эхэлдэг вэ? Газрын зураг дээрээс харагдахын аргагүй жижигхэн, гэр оронд ойрхон хамгийн жижиг газраас эхэлдэг”

Элеанор Рузвельт

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалыг боловсруулах зөвлөлийн дарга, 1958⁵

4 НҮБХЭДКГ “Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 70 жилийн ой, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссар Мишель Бачелет хэлсэн үг. 2018 оны 12-р сарын 6. <https://www.ohrh.org/en/press-releases/2018/12/70th-anniversary-universal-declaration-human-rights>.

5 Нэгдсэн Үндэстний Байгууллага “Сургалтын гарын авлага, эх сурвалж: Хүний эрх”-ээс харна үү” <https://www.un.org/en/%E2%80%9Cclose-home%E2%80%90universal-declaration-human-rights-0>

Хүний эрхийн Түгээмэл тунхаглал



Эрх чөлөө, тэгш байдал



Амьдрал, эрх чөлөө, аюулгүй байдал



Эрүү шүүлт тулгахыг хориглох



Хүн бүр эрх, эрх чөлөөтэй



Боолчлол, бусдын эрхшээлд байлгахыг халах



Эрх зүйн чадвараа хүлээн зөвшөөрүүлэх



Хууль зүйн тусалцаа



Шударгаар, нээлттэй шүүлгэх



Гэм буруугүйд тооцогдох



Улсынхаа дотор болон гадаадад чөлөөтэй зорчин явах



Гэрлэлтийн эрх тэгш байдал, гэр бүл хамгаалал



Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх эрх чөлөө



Хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө



Ардчилсан үйл явцад оролцох

Дур мэдэн хорьж саатуулахыг хориглох



Хувийн өмч



Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө



Амрах, зав чөлөөтэй байх



Боловсрол



Нийгмийн болон олон улсын дэг журам



Эрүүл мэнд, аж амьдралын сайн сайхан



Соёл



Нийгэм



Хуулийн өмнө эрх тэгш байх



Хөдөлмөрлөх, үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх



Нийгмийн хамгаалал



Иргэний харьяалал



Орогнох эрх



Энэхүү тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг хүндэтгэх

Хүний эрхийн олон улсын билл

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь олон түвшинд шинэлэг байсан. НҮБ-ын дүрэмд заасан “хүний эрх” гэсэн нэр томъёог анх удаа тодорхойлоод зогсохгүй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт гэсэн олон талт хоёр чухал гэрээний үндэс болсон юм. Эдгээр пактуудын бичвэр дээр зөвшилцөж санал нэгдэхэд 20 жил шаардагдсан бөгөөд 1976 онд хүчин төгөлдөр болсон билээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хоёр пактыг хамтад нь Олон улсын хүний эрхийн билл гэдэг.

Пактуудад олон улсын хүний эрхийн бусад 8 гэрээ нэмэлт болдог ба эдгээр нь арьс өнгөөр ялгаварлах, тарчлаах зэрэг тодорхой асуудал, эсхүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт тодорхой бүлгүүдийн эрхийг хамгаалах асуудлаар байгуулагдсан. Эдгээр гэрээг соёрхон баталсан улс орнууд гэрээгээр хамгаалж буй хүний эрхийг хүндэтгэж, сахин хамгаалах үүрэг хүлээдэг.

Мөн бус нутгийн хэд хэдэн байгууллага хүний эрхийн гэрээг баталсан байдаг. Тухайлбал, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенци (Хүний эрхийн тухай Европын конвенци хэмээн илүү түгсэн)⁶, Хүний эрхийн тухай Америкийн конвенци⁷, Хүний болон хүмүүсийн эрхийн тухай Африкийн тунхаг⁸, Хүний эрхийн тухай Арабын тунхаг⁹. Эдгээр гэрээ, баримт бичгийн хэрэгжилтэд бүс нутгийн хүний эрхийн механизмаар дамжуулан хяналт мониторинг хийнэ.

6 Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Конвенци (1950) <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/005?module=treaty-detail&treaty-num=005>

7 Хүний эрхийн тухай Америкийн конвенци (1969) https://www.oas.org/dil/treaties_B-32_American_Convention_on_Human_Rights.htm

8 Хүний болон хүмүүсийн эрхийн тухай Африкийн тунхаг (1981) <https://www.achpr.org/legalinstruments/detail?id=49>

9 Хүний эрхийн тухай Арабын тунхаг (2004) <https://digitallibrary.un.org/record/551368?ln=en>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт

Иргэний болон улс төрийн эрх нь хүний эрхийг хангахад зайлшгүй чухал юм. Үүнд хүмүүсийн санаа онооны нэгдэлд суурилсан ардчилсан засаглалын гол суурь болсон хүний үндсэн эрх чөлөөтэй холбоотой төрийн үйл хэрэгт оролцох эрх багтана. Эдгээр эрх нь парламентын гишүүдийн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй салшгүй холбоотой тул парламентын гишүүдийн хувьд илүү чухал байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын гишүүн орнууд энэхүү гэрээнд тусгасан эрхийг хамгаалах, мөн тодорхой эрх зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй засч залруулах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг. Энэхүү пактын цар хүрээг нэмэлт хоёр протокол¹⁰ илүү өргөжүүлж, хүний эрхийн хамгаалалтыг илүү хүчтэй болгодог. Эхний нэмэлт протокол нь энэхүү протоколыг соёрхон баталсан улс орны иргэд, хувь хүн пактад заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл НҮБ-ын энэхүү протоколын хэрэгжилтэд мониторинг хийх үүрэг бүхий НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд гомдол гаргах эрхтэй байна. Хоёр дахь нэмэлт протокол нь цаазын ялыг устгах зорилготой¹¹.

-
- 10 Нэмэлт протокол нь хүлээх үүргийг тодорхойлсон мөн өргөдөл гомдол гаргах процедур зэрэг хамгаалах механизмыг тодорхойлдог хүчин төгөлдөр гэрээтэй холбоотой эрх зүйн арга хэрэгсэл байна. Хэдийгээр үргэлж биш боловч, ихэнх тохиолдолд суурь гэрээнд нэгдсэн орсон улс орнуудын хувьд соёрхон батлах болон нэгдэх эрхийг олгодог. Суурь гэрээнд нэгдсэн орсон улс орнууд заавал энэхүү протоколд нэгдэн орох ёстой гэж үздэггүй тул нэмэлт буюу optional протокол гэдэг.
- 11 Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын нэмэлт протокол (1966 онд батлагдан, 1976 онд хүчин төгөлдөр болсон), энэхүү пактын хоёр дахь нэмэлт протокол нь цаазын ялыг устгах зорилготой (1989 онд батлагдсан)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пакт

Олон улсын Хүний эрхийн конвенцын хоёр дахь тулгуур болох Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактаар айх аюулаас ангид, хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын болон иргэний, улс төрийн эрхээ эдлэх боломжтой нөхцөлөөр хангагдсан тохиолдолд хүрэх боломжтой хүн төрөлхтөний төгс байдлыг хүлээн зөвшөөрдөг.¹² Пактын дагуу гишүүн орнууд өөрийн эдийн засгийн нөөц бололцоо болон олон улсын стандартын хамгийн доод түвшинг харгалзахын сацуу эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах таатай орчин бүрдүүлэх үүрэгтэй.

Гишүүн орнууд өөрийн улсын хэмжээнд Пактад заасан хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, сахин биелүүлэх үүрэгтэй бөгөөд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөвлөлд өөрсдийн хэрэгжүүлж буй бодит үйл ажиллагааны талаар тогтмол тайлагнана.¹³

Олон улсын хүний эрхийн билл нь хүний эрхийн бусад хэм хэмжээ, гомдол гаргах механизмыг бүрдүүлэх, тайлагнах, асуулга авах процедур болон бусад асуудлуудтай холбоотой бусад тодорхой, дагаж мөрдөж нэмэлт зохицуулалтуудаар баяжсан. Дээрх хоёр пакт, эдгээр гэрээ болон нэмэлт протоколуудыг хамтад нь “хүний эрхийн суурь гэрээнүүд” гэж үздэг.

¹² Пактын 6, 9, 11, 13 дугаар зүйлийг харна уу

¹³ Пактын нэмэт протокол, 2008 онд батлагдан, 2013 оноос хүчин төгөлдөр болсон

НҮБ-ын хүний эрхийн гэрээ, конвенц

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын нэмэлт протокол (1976) цаазын ялыг устгах зорилго бүхий Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын нэмэлт протокол

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пакт

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактын нэмэлт протокол (2013)

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол (2006)

Хүүхдийн эрхийн тухай конвенци

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оруулах, худалдаалах, биеийг нь үнэлүүлэх, садар самуунд уруу татахын эсрэг нэмэлт протокол (2000) Хүүхдийн эрхийн тухай конвенцийн мэдээлэл хургуулах тухай нэмэлт протокол (2011)

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенци

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол (2000)

Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийн устгах тухай олон улсын конвенци

Хүүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенци

Цагаач иргэд болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай Олон улсын конвенци

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай конвенци

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай конвенцийн нэмэлт протокол

Прогрессив буюу дэвшилтэт хэрэгжилтийн зарчмууд

Прогрессив буюу дэвшилтэт хэрэгжилтийн зарчмууд гэдэг нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон улс орнууд нэн даруй арга хэмжээ авах, цаашид өөрсдийн нөөц боломжийг бүрэн дайчилж эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг прогрессив байдлаар бүрэн хангаж хэрэгжүүлэх явдал юм. Тухайлбал, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хүн бүр хамгийн сайн эрүүл мэндийн үйлчилгээг авах эрхийг шүүд баталгаажуулдаггүй. Гэвч, улс орнууд эдийн засгийн чадамж ба нийгэм, соёлын уламжлал мөн олон улсын зайлшгүй хангах стандартад нийцүүлэн хүмүүс эрүүл мэндийн суурь үйлчилгээг зарчмын хувьд авах боломжийг баталгаатай хангах, улмаар эдгээр үйлчилгээг өргөжүүлэх байдлаар нийтийн эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх үүргийг хүлээнэ. Прогрессив хэрэгжилтийн зарчмууд нь мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактад нэгдэн орсон улс орнууд хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бууруулахад хүргэх ухарсан арга хэмжээ авахгүй байх үүрэгтэй.

Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилгууд


Нягт уялдаа холбоо: Хүний эрх нь 2030-зорилгыг нийтээр түгээмэл хэрэгжүүлэх явдалтай нягт холбоотой байна.

Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ) 2030 нь олон улсын хүний эрхийн стандартад бат бөх суурилсан. Энэ нь эрх тэгш байдал, үл алагчилах, тэгш хамруулах зарчмыг чухалчилж, бүх хүмүүсийн хүний эрхийг хангах, хэрэгжүүлэхийг зорино. ТХЗ-ын 17 зорилго, тэдгээрийн 169 шалгуур үзүүлэлт нь тогтвортой хөгжлийн 3 гол тулгуур болох эдийн засаг, нийгэм, байгаль орчны¹⁴ хувьд цогц байдлаар хувь нэмэр оруулахаар боловсруулагдсан. Хэд хэдэн шалгуур үзүүлэлт нь хүний эрхийн холбогдох агуулгыг тусгасан бол ТХЗ-ын ихэнх нь эдийн засаг, нийгэм соёлын болон иргэний ба улс төрийн эрхтэй нягт уялдаатай байдаг. Тухайлбал, энх тайван, тэгш хамруулсан нийгмийг цогцлоох талаарх засаглалын зорилт гэж мөн нэрлэгддэг Зорилт-16 нь хувь хүний аюулгүй байдал, шударга шүүхээр шүүлгэх, үндсэн эрх чөлөө зэрэг иргэний ба улс төрийн эрхийг олон талаас нь хөнддөг¹⁵.

Зураг 4. Тогтвортой хөгжлийн зорилго 16 ба хүний эрх¹⁶

16

ЭНХ ТАЙВАН
ШУДАРГА
ЁСЫГ ЦОГЦЛООХ



Тогтвортой хөгжлийг бий болгох энх тайван, бүгдийг тэгш хамруулсан нийгмийг цогцлоох; хүн бүр хуулийн өмнө тэгш байх, бүх шатанд үр дүнтэй, хариуцлагатай, тэгш хамруулсан институцийг бэхжүүлэх

Хүчирхийллийн бүхий л хэлбэрийг устгах, хүүхдийг худалдаалах хүчирхийллийг таслан зогсоох, хууль дээдлэх ёс, хүн бүр шүүхийн өмнө тэгш байх явдлыг хангах, хууль бус санхүүгийн болон зэвсгийн урсгалыг багасгах, үр дүнтэй институцыг бэхжүүлэх, бүх шатанд шийдвэр гаргах үйл явцад оролцоог хангах, хүн бүрийн хувьд эрх зүйн статусыг зөвшөөрөх

- Хүний амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулаас ангид байх эрх (ХЭТТ 3-р зүйл, 6.1, 9.1, ХАБХБҮК 7-р зүйл)
- Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, хүч хэрэглэх, мөлжлөгөөс хамгаалах (ХЭХК 19, 37-а зүйл, хүүхдийн наймаа ХЭХК 34-36-р зүйл, ХЭХК-ын нэмэлт протокол 1)
- Шүүхийн өмнө хүн бүр ижил тэгж байх, шударга шүүхээр шүүлгэх (ХЭТТ 8, 10-р зүйл, ИУТЭТОУП 2.3 зүйл, 14-15-р зүйл, ЭЭБХТХЗК 2.с зүйл)
- Хууль эрх зүйн хувьд бие даасан байх эрх (ХЭТТ 6-р зүйл, ИУТЭТОУК, 16-р зүйл, ХБИЭТК 12-р зүйл)
- Төрийн үйл хэрэгт оролцох эрх (ХЭТТ, 21-р зүйл, ИУТЭТОУП, 25-р зүйл)
- Мэдээлэл олж авах эрх (ХЭТТ, 19-р зүйл, ИУТЭТОУП, 19.2 зүйл)

14 Илүү мэдээллийг ОУПХ-ноос ТХЗ-ын талаар гаргасан Парламент ба Тогтвортой хөгжлийн зорилтууд: өөртөө хийх үнэлгээний аргачлал-аас харна уу. <https://www.ipu.org/file/2549/download>

15 НҮБХЭДКГ, Дэлхий ертөнцөө өөрчлөх: Тогтвортой хөгжлийн зорилт-2030 дахь Хүний эрх (Женев хот, НҮБХЭДКГ, 2015) <https://www.ohchr.org/Documents/issues/MDGs/Post215/TransformingOurWorld.pdf>

16 НҮБХЭДКГ ТХЗ болон хүний эрхийн хоорондын холбооны жишээг харуулсан хүснэгтийг боловсруулсан. https://www.ohchr.org/Documents/Publications/Session5_OHCHR_SDG_HR_Table.pdf

Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилгууд

2 ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ

Олон улсын хамтын ажиллагаа
(ХЭТТ, 28-р зүйл, ЭЗНСОУП 2.11, 11.21)

Хангалттай хүнс тэжээлээр хангагдах эрх
(ХЭТТ, 29-р зүйл, ОУЭЗНСП 11-р зүйл, ХЭК 24.2.с)

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, САЙН САЙХАН АМЬДРАХ

Амьд авах эрх
(ХЭТТ, 3-р зүйл, ИУТТОУП, 6-р зүйл) эмэгтэйчүүдийн
(ЭЯГБХУТК, 12-р зүйл), хүүхдийн оролцоо (ХЭК 6-р зүйл)

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
(ХЭТТ, 25-р зүйл ЭЗНСЭТОУП, 12-р зүйл) эмэгтэйчүүдийн
(ЭЯГБХУТК, 12-р зүйл), хүүхдийн оролцоо (ХЭК 14-р зүйл)

**Шинжлэх ухааны дэвшил, түүний хэрэглээнээс үр
шимийг хүртэх эрх**
(ХЭТТ, 27-р зүйл, ЭЗНСЭТОУП, 15.1.в-р зүйл)

Эх ба хүүхдийг тусгайлан хамгаалах
(ЭЗНСЭТОУП, 10-р зүйл)

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

Боловсрол эзэмших эрх
(ХЭТТ, 26-р зүйл, ЭЗНСЭТОУП, 13-р зүйл), ялангуяа
хүүхдийн хувьд (ХЭК 28, 29-р зүйл), хөгжлийн
бэрхшээлтэй иргэд (ХЭК 23.13-р зүйл, ХБИК 24-р
зүйл), үүгүүл иргэд (НУБУИЭТТ 14-р зүйл)

**Эмэгтэйчүүд, охид боловсролын салбарт ижил
тэгш байх эрх**
(ЭЯГБХУТК, 10-р зүйл)

**Техникийн болон мэргэжлийн сургалт зэрэг
бүхий л салбарт хөдөлмөрлөх эрх**
(ЭЗНСЭТОУП, 6-р зүйл)

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

**Зохистой хөдөлмөр ба хөдөлмөрийн шударга, таатай
орчныг бүрдүүлэх**
(ХЭТТ, 23-р зүйл, ЭЗНСЭТОУП, 6, 7, 10-р зүйл, ХЭК 34-36-р
зүйл, ОУХБ-ын Хөдөлмөрийн конвенци, ОУХБ-ын
Ажлын байран дахь үндсэн зарчим ба эрхийн тунхаг)

**Боолчлол, хүчээр хөдөлмөрлүүлэх, хүний наймааг
хориглох**
(ХЭТТ, 4-р зүйл, ЭЯГБХУТК, 6-р зүйл, ХЭК 34-36-р зүйл)

**Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эмэгтэйчүүдийн
ижил тэгш эрх**
(ЭЯГБХУТК, 11-р зүйл), ОУХБ-ын Конвенци №100, 111

Хүүхдийн хөдөлмөрийг хориглох
(ХЭК 32-р зүйл, ОУХБ-ын Хөдөлмөрийн конвенци №182)

**Шилжин суурьшигч ажилчдын хөдөлмөр эрхлэх
ижил тэгш эрх** (ШСАК 25-р зүйл)

6 ЦЭВЭР УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

Боловсрол эзэмших эрх
(ХЭТТ, 26-р зүйл, ЭЗНСЭТОУП, 13-р зүйл), ялангуяа
хүүхдийн хувьд (ХЭК 28, 29-р зүйл), хөгжлийн
бэрхшээлтэй иргэд (ХЭК 23.13-р зүйл, ХБИК 24-р
зүйл), үүгүүл иргэд (НУБУИЭТТ 14-р зүйл)

**Эмэгтэйчүүд, охид боловсролын салбарт ижил
тэгш байх эрх**
(ЭЯГБХУТК, 10-р зүйл)

**Техникийн болон мэргэжлийн сургалт зэрэг
бүхий л салбарт хөдөлмөрлөх эрх**
(ЭЗНСЭТОУП, 6-р зүйл)

Харилцан нэгнээ нөхсөн, нэмэлт хандлага

2030 зорилгуудын ТХЗ-ийн 17 зорилго, 169 зорилтот түвшинд хүрэх талаар гишүүн орнууд томоохон үүрэг хүлээсэн. ТХЗ-ыг ахиулан хэрэгжүүлэх нь улс орны нөөц бололцоо, үр дүнтэй ахиц гаргах талаарх хичээл зүтгэлээс хамаарна. Улс орны парламент нь эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх хууль тогтоомж батлах, төсөвт шаардлагатай санхүүжилтийг суулгах заалтуудыг оруулах зэргээр ТХЗ-ыг амжилттай урагшлуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг. Парламентууд баталж буй хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт нь олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн байх нөхцөлийг хангах шаардлагатай. Түүнчлэн парламент нь ТХЗ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлд засгийн газрыг хариуцлагатай байх явдлыг хангах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Зарим улсын парламент ТХЗ-ыг хэрэгжүүлэх талаар чухал том алхмуудыг хийгээд байна. Жишээ нь, 2016 онд Зимбабве Улсын парламент ТХЗ-ыг хариуцсан Зөвлөлийн үйл ажиллагааг өргөтгөж, 2030-зорилгын хэрэгжилтэд анхаарч ажиллахаар болсон. ТХЗ-ыг хариуцсан өргөтгөсөн Зөвлөлийн гол чиг үүрэг нь “засгийн газрын бодлого нь ТЗХ-ын хүрээнд болон тэдгээртэй үялдаа холбоотойгоор хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих”¹⁷ юм. Зөвлөл мөн “Нэгдсэн Үндэстний Байгууллагад тайлагнах ээлжит тайлан боловсруулахад”¹⁸ идэвхтэй оролцох, үндэсний бодлогын тогтолцоо, стратеги, төлөвлөгөө, төсвийг батлан хэрэгжүүлэхдээ ТХЗ-ыг тусгасан байх нөхцөлийг хангахад парламентыг илүү оролцоотой байлгах” зорилготой¹⁹.

Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилгуудын хоорондын холбоог судалсан өгөгдлийн сан

Дани улсын Хүний эрхийн институтээс хөгжил ба хүний эрхийн хоорондын шууд хамаарлыг харуулсан интерактив өгөгдлийн санг боловсруулсан байна. НҮБ-ын хүний эрхийн талаарх 50.000 гаруй зөвлөмжийг судалсан энэхүү өгөгдлийн сан нь хэрэглэгчдэд дэлхийн хэмжээнд тогтвортой хөгжил ба хүний эрхийн зорилтуудыг хэрэгжүүлснээр гарсан ахиц, үр дүнг дүрслэлийн аргаар харах боломжийг олгодог.²⁰

17 Зимбабве Улсын Засгийн газар. Зимбабвегийн Үндэсний сайн дурын дүгнэлт. (Хараре: Зимбабвегийн Засгийн газар 2021) 47 хуудас <https://www.mpslsw.gov.zw/download/zimbabwe-second-voluntary-national-review-report/>

18 Дээрхтэй адил

19 Дээрхтэй адил

20 Дани Улсын Хүний эрхийн институт “Хүний эрх ба 2030 зорилтын хоорондын холбоо” 2019 оны 1-р сарын 14. <https://sdgdata.humanrights.dk/en/node/252884>

Улс орны хүний эрхийн чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд олон улсын хүний эрхийн ямар механизмууд хяналт тавьдаг вэ?

Улс орнууд нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээг хэрэгжүүлэх чиглэлээр үндэсний хууль эрх зүйн орчинг бүрдүүлж шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Энэ ажилд тухайн улс орны засгийн газар, төрийн байгууллагууд хамтран оролцох шаардлагатайгаас гадна гарч буй ахиц дэвшлийг тогтоох, хариуцлагын тогтолцоог хангахын тулд олон улсын хүний эрхийн механизмаас тогтмол мониторинг хийж байх шаардлагатай байдаг.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан дүгнэлт, тусгай процедур

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийг хүний эрхийн талаарх өргөн хүрээтэй асуудлыг хянах бүрэн эрхтэйгээр 2006 онд Ерөнхий Ассемблейн 60/251 тоот тогтоолоор өмнө ажиллаж байсан Хүний эрхийн комиссын оронд байгуулагдсан. Зөвлөл нь НҮБ-ын гишүүн 47 орноос²¹ бүрдэх ба жилд гурваас доошгүй удаа хуралдана (2-3 дугаар сард, 6-7 дугаар сард, 9-10 дугаар сард). Нийт гишүүн орнуудын гуравны нэгээс дээш нь хүсэлт гаргасан тохиолдолд хүний эрхийн зөрчил болон яаралтай асуудлаар тусгай чуулганыг хэдийд ч зарлан хуралдуулж болно. Тус Зөвлөл хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR), тусгай журам болон гомдол²² шийдвэрлэх зэргээр дэлхий нийтийн хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдалд мониторинг хийх хэд хэдэн механизмыг ашигладаг.


Комиссын ажлын хэсгээс гадна бусад механизмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа Хүний эрхийн зөвлөл хөгжих эрх, уугуул хүмүүсийн эрх, Дурбаны тунхаглалыг хэрэгжүүлэх, Үйл ажиллагааны хөтөлбөр, цэргийн болон тусгай компаний үйл ажиллагааны зохицуулалтын орчин, энх тайвнаар зэрэгцэн орших эрх, тариачдын эрх болон хөдөө нутагт ажиллаж буй хүмүүсийн эрх зэрэг тодорхой сэдвийн хүрээнд шинэ механизмуудыг ашиглаж байна. Зөвлөлийн бусад харьяа байгууллагууд нь Цөөнхийн асуудлаарх форум, Нийгмийн форум, Бизнес ба хүний эрхийн форум, Хүний эрх, ардчилал болон эрх зүйт ёсны форум зэрэг багтана. Зөвлөл нь олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй нөхцөлийг мөшгин шалгах зорилгоор баримт нотолгоо цуглуулах ажлын хэсэг, комисс зэрэг эрэн сурвалжлах механизмыг мөн байгуулж болно.

21 Сонгогдсон гишүүн орнууд эхний гурван жилийн хугацаанд ажиллаж ба дараалан хоёр удаа сонгогдох боломжгүй

22 A/HRC/RES/5/1.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)

Ерөнхий Ассемблейгээс 2006 онд байгуулсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR) нь Хүний эрхийн зөвлөлийн механизм юм. Энэ нь хамтын ажиллагааны механизм бөгөөд хүний эрхийн төлөв байдлыг сайжруулах үндсэн зорилгоор НҮБ-ын гишүүн 193 орны хүний эрхийн чиглэлээр өгсөн амлалт, үүрэг, хэрэгжүүлж буй ажлыг бусад гишүүн орнууд нь дүгнэн



хэлэлцдэг үйл явц юм. Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн ажлын хэсэг нь гишүүн улс бүрийг 4.5 жил тутамд авч хэлэлцдэг. Энэ утгаараа Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR) нь цикл буюу орчилт үйл явц юм. Энэ нь аль болох өргөн хүрээнд парламент болон бусад холбогдох талуудын оролцоог ханган зөвшилцөх үйл явцын дүнд гаргасан улс орны тайланд үндэслэдэг. Тухайн хэлэлцэгдэж буй улсын танилцуулах тайлангаас гадна НҮБ-ын Хүний эрхийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газраас хоёр тайланг нэгтгэдэг. Нэг нь төрийн бус байгууллагууд болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудаас²³ ирүүлсэн мэдээлэл байна. Хоёр дахь нь гэрээний хэрэгжилтэд мониторинг хийдэг байгууллага, тусгай эрх бүхий этгээд, бие даасан шинжээч нарын дүгнэлт зөвлөмжүүдийг нэгтгэсэн мэдээлэл болон НҮБ-ын бусад байгууллагын гаргасан мэдээлэл байна. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR) нь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах талаар хийсэн ажлуудаа танилцуулах боломжийг улс оронд өгөхийн зэрэгцээ тэдэнд хүний аливаа эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хариуцлагынх нь талаар мөн сануулдаг.

23 Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаар 28 дугаар хуудаснаас нэмэлт мэдээлэл авна уу.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн үйл явцад парламент болон бусад талууын оролцоо нь чухал болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх

2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Хүний эрхийн зөвлөл 35/29 тоот тогтоолоо баталж, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн хүрээнд тухайн улс зөвлөмжийн хэрэгжилт болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ үндэсний хууль тогтоомж, бодлогод тусгахад парламент чухал үүрэг гүйцэтгэх"-ийг онцолсон²⁴. Тус тогтоол нь оролцогч улсуудыг улс орныхоо хууль эрх зүйн орчны хүрээнд парламент Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн бүхий л үе шатанд оролцохыг уриалсан.²⁵ Стратегийн түнш болохын хувьд улс орны тайлангийн талаар зөвшилцөх тал мөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэхэд парламентын байр суурийн талаар онцолсон.²⁶

Тусгай процедур

Тусгай процедур²⁷ нь Хүний эрхийн зөвлөлөөс тодорхой улс орон болон дэлхий нийтэд хамааралтай тодорхой асуудлыг шийдэхээр зөвшөөрсөн механизм юм. Тусгай процедурыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь хувь хүн (тухайлбал тусгай элч, төлөөлөгч эсхүл бие даасан шинжээч гэх мэт) эсхүл ажлын хэсэг байж болно. Тэд сайн дурын үндсэн дээр ажиллах шилдэг экспертүүд байх ба Зөвлөлөөс томилогдоно. Энэ систем нь НҮБ-ын хүний эрхийн тогтолцооны гол цөм байх ба иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн гээд хүний эрхийн бүхий л чиглэлээр мөн тодорхой бүлгийн эрх, улс орны онцлог бүхий нөхцөл байдал зэрэг асуудлыг хамаарна. Эрх бүхий этгээд нь Хүний эрхийн зөвлөлд жил бүр тайлагнах ба ихэнх тохиолдолд Ерөнхий Ассемблейд мөн давхар тайлагнадаг.

24 A/HRC/RES/35/29

25 Дээрхэй адил

26 Дээрхэй адил

27 Нэмэлт мэдээллийг Хүний эрхийн асуудал эрхэлсэн дээд комиссар "Хүний эрхийн зөвлөлийн тусгай журам" <https://www.ohchr.org/EN/HRBodies/SP/pages/Welcomepage.aspx>

Хүний эрхийн асуудлаарх Дээд комиссарын дэмжлэгтэйгээр тусгай процедур хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь дараах болон бусад ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улс оронд очиж ажиллах
- Мэдээлсэн зөрчилд холбогдох кэйс дээр ажиллах, улс орон, бусад холбогдох талуудтай холбогдож, тэдний анхаарлыг гарсан зөрчил, хүчирхийллийн асуудалд хандуулах байдлаар илүү өргөн хүрээнд, системтэйгээр асуудлыг авч үзэх
- Тодорхой асуудлаар судалгаа хийх, мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх ажлыг зохион байгуулах
- Олон улсын хүний эрхийн стандартыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах
- Сурталчлан таниулах ажил хийх, техник хамтын ажиллагаанд зөвлөгөө өгөх

НҮБ-ын Хүний эрхийн гэрээний байгууллагууд

Олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтэд гэрээний мониторингийн алба, гэрээний алба гэж нэрлэгддэг бие даасан шинжээчдийн зөвлөл хяналт тавина²⁸. Гэрээний алба нь холбогдох гэрээний хэрэгжилтийн талаар улс орны өргөн мэдүүлсэн тайланг хянадаг. Одоогийн байдлаар 10 гэрээний алба ажиллаж байна.²⁹ Үүнд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг³⁰ Дэд хороо багтах ба энэ нь тайланг хянах бус харин Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас сэргийлэх зорилгоор хорих газруудад очиж ажиладаг.

28 Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн систем нь дүрэмд-суурилсан болон гэрээнд-суурилсан албадаас ерөнхийдээ ялгаатай байдаг. Гэрээнд суурилсан алба нь хүний эрхийн тодорхой гэрээнээс урган гардаг. Дүрэмд суурилсан алба нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтуудын дагуу байгуулагддаг. Түүнд Хүний эрхийн комиссын оронд байгуулагдсан Хүний эрхийн зөвлөл болон бусад тусгай албад багтана.

29 Нэмэлт мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний албаны жагсаалтаас харна уу. OHCHR “гэрээний алба” <https://www.ohchr.org/EN/HRBodies/Pages/Overview.aspx>

30 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс сэргийлэх Дэд хороо 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс сэргийлэх Конвенцийн дагуу байгуулсан.

Улс орны тайлагнах процедур нь хүний эрхийн 10 суурь гэрээнд бүгдэд нь (Дэд зөвлөлөөс бусад тохиолдолд) нийтлэг хамаатай зайлшгүй биелүүлэх шинж бүхий ганц процедур юм. Гишүүн улс орнууд нь гэрээний талуудад анхны тайлангаа хүргүүлэх үүрэгтэй бөгөөд үүний дараа хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайланг хүргүүлнэ. Зарим тохиолдолд, дүгнэлт хэлэлцүүлэгт орж буй талаас яаралтай болон бусад шаардлагатай тайланг гаргах хүсэлт гаргаж болно. Улс орны тайланд олон талын байр суурийг хамруулах үүднээс төрийн бусад байгууллага, парламент, ХЭҮК, шүүх, холбогдох төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг урьж оролцуулахыг засгийн газруудад зөвлөдөг.

Гэрээний талууд улс орны тайланд дүн шинжилгээ хийж, тухайн улсын болон олон нийтийн төлөөллийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлгээр авч хэлэлцдэг. Улс орон тус бүрийн тайлантай танилцсаны дараа гэрээний талууд дүгнэлт ажиглалт болон зөвлөмж боловсруулж гаргадаг. Улсууд нь эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх ба энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг дараагийн тайландаа тусгана³¹.

Гэрээний талуудын 6 нь (Арьс өнгөөр алагчилах байдлыг устгах Зөвлөл, Хүний эрхийн Зөвлөл, Эмэгтэйчүүдийн эсрэг гадуурхлыг таслан зогсоох Зөвлөл, Тарчлаан зовоохын эсрэг Зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудал хариуцсан Зөвлөл, Хүчээр алга болгохыг устгах асуудал хариуцсан Зөвлөл) тодорхой нөхцөлд гэрээний гишүүн улс орон өөрийнх нь холбогдох гэрээнд заасан эрхийг зөрчсөн гэсэн хувь хүний гомдлыг хүлээн авч болдог. Зөвлөл тухайн гомдлыг хүлээн авах боломжтой гэдгээ мэдэгдсэнээр тухайн гомдлыг өөрийн шалгуурын хүрээнд авч үзэж эхлэх ба холбогдох гэрээний заалтын дагуу эрхийн зөрчил болсон эсхүл болоогүй гэж дүгнэсэн шалтгаанаа мэдэгдэнэ.

31 НҮБХЭДКГ гэрээний талуудын нэгдсэн санг бий болгосон. Үүнд гэрээний талуудын боловсруулсан нийтэд нээлттэй болгох боломжтой баримт мэдээллийг багтаасан. Илүү мэдээллийг НҮБ ХЭДКГ "НҮБ Гэрээний талуудын нэгдсэн сан"-аас авах боломжтой. <https://tbinternet.ohchr.org/SitePages/Home.aspx>.

Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх Парламентын чиг үүрэг

Үндэсний түвшинд парламентын хүлээх үүрэг

Парламент нь үндэсний хэмжээнд хүний эрхийг хамгаалах тогтолцооны гол цөм нь байдаг. Парламент нь эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хууль дээдлэх ёс, шүүх засаглал зэрэг түүний институцийн үндэс суурийг тогтоодог бөгөөд эдгээр нь олон улсын ба бүс нутгийн хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байх явдлыг хангана. Гүйцэтгэх засаглалын бодлого, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих замаар парламент хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах талаарх үндсэн үүргээ биелүүлэхэд засгийн газарт дэмжлэг үзүүлэх боломжтой. Мөн парламент нь хууль тогтоох болон хяналтын чиг үүргээс гадна хүний эрхийг хэрэгжүүлэхэд шууд үр нөлөө үзүүлдэг улсын төсвийг баталдаг.

Парламент нь хүний эрхийг сахин хамгаалагч байх үүргээ биелүүлэхэд парламентын гишүүд, ажлын албаны ажилтнууд нь олон улсын хүний эрхийн холбогдох хууль эрх зүйн тогтолцоо, онц байдал зарлах үе дэх парламентын гүйцэтгэх үүрэг зэрэг парламентын бусад процедурын талаар сайтар мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай. Парламент бол төлөөллийг хангасан байх, парламентын гишүүдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах зэрэг бусад хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Хүний эрхийн гэрээ, конвенцийг соёрхон батлах

Хүний эрхийн гэрээ, конвенцийг соёрхон баталснаар³² тухайн улс орон олон улсын болон өөрийн улсын холбогдох талуудын өмнө хүний эрхийн талаар амлалт авч буйгаа илэрхийлнэ. Соёрхон батлах үйл явц нь гүйцэтгэх засаглал тухайн хүний эрхийн гэрээнд гарын үсэг зурснаар эхэлнэ. Ихэнх улсад тухайн улсын нэгдэж орж буй гэрээ хууль ёсны болсноор олон улсын хүний эрхийн хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгааг бий болгож, соёрхон баталгаажуулах явдлыг парламент батлах гол үүрэгтэй байдаг бол зарим улсад гэрээний хэрэгжилтийн талаар олон улсын нийгэмлэгт тайлагнах эрхийн механизмыг бүрдүүлдэг. Хосолмол эрх зүйн тогтолцоо бүхий улс орны хувьд гэрээний заалтуудыг үндэсний хууль тогтоомжтой уялдуулахад нэмэлт хууль тогтоомж батлах хэрэгтэй болж болзошгүй. Парламент гүйцэтгэх засаглалыг нэгдэн ороогүй байгаа гэрээг соёрхон батлахыг уриалж дэмжих болон соёрхон баталсан гэрээний үндэслэлгүй зохицуулалтаас татгалзах талаар дэмжлэг үзүүлж болно.

32 Улс орнуудын соёрхон баталсан эсэх статусын талаарх илүү мэдээллийг НҮБХЭДКГ: “Соёрхон баталсан байдал интерактив сан”-аас харна уу. <https://indicators.ohchr.org/>

Эрх зүйн таатай орчин бүрдүүлэх хууль тогтоомжийг батлах

Хэдийгээр олон улсын хүний эрхийн гэрээнд гарын үсэг зурж соёрхон батлах нь эдгээр гэрээг заавал дагаж мөрдөх эрх зүйн шинжтэй болгох эхний алхам боловч үндэсний хэмжээнд эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх нь тухайн гэрээ амьдралд бодитой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ. Хүний үндсэн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хууль тогтоомж батлах³³ замаар парламент олон улсын хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ бодитой хэрэгжүүлдэг. Улс орондоо нутагшуулах үйл явцад мөн парламент олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээтэй уялдуулах нөхцөлийг хангахын тулд хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжуудаа дүгнэж үнэлэх ажил багтана. Хуулийн төсөл, санал санаачилга, өргөдөл гомдлыг хүний эрхийн өнцгөөс харж хянадаг болох тул Парламентын үйл ажиллагаанд хүний эрхийн асуудлыг тусгах нь мөн адил маш чухал юм.

Эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах талаарх парламентын үйл ажиллагаа³⁴

Кувейт Улс Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн. 2005 онд эмэгтэйчүүд анх удаа санал өгөх, сонгуульд оролцох эрхтэй болсон. 2020 онд Кувейтын Үндэсний Ассемблей эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай шинэ хуулийг батлав. Уг хууль 2020 оны 9 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон³⁵.

2019 онд Италийн Сенатаас Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд Codice Rosso буюу Улаан хууль гэх шинэ хуулийг батлан гаргасан. Энэхүү хууль нь тухайлбал, гэмт үйлдлийн талаар мэдэгдсэнээс хойш 3 хоногт багтаан улсын прокурор дээр хэлэлцдэг байх зэргээр гэр бүлийн болон жендэрт сүүрилсэн хүчирхийллийн кэйсийг түргэн шуурхай шалгаж тогтоодог байхаар батлагдсан. Түүнчлэн хуульд хүчээр гэр бүл болох, хүчил хэрэглэн бусдын нүүрийг гэмтээх, бэлгийн харилцаанд орж буй зураг, бичлэгийг хууль бусаар түгээх зэрэг шинэ төрлийн гэмт хэргүүдийг мөн тусгасан³⁶.

33 Улс орны хууль тогтоомжид олон улсын гэрээг нийцүүлэн тусгах журмыг гол төлөв тухайн улсын Үндсэн хуульд заасан байдаг. Нэмэлт мэдээллийг ОУПХ ба НҮБХЭДКГ, Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага-№26, 97 дахь хуудаснаас харна уу.

34 Нэмэлт мэдээллийг ОУПХ-ны парламент дахь жендеримйн мэдрэмжит байдлыг хангах талаарх арга хэмжээ ОУПХ. Парламентын жендерийн мэдрэмжит байдлыг үнэлэх нь: Өөртөө үнэлгээ хийх аргачлал -аас үзнэ үү. (Женев хот, ОУПХ 2016). <https://archive.ipu.org/pdf/publications/gender-toolkit-e.pdf>.

35 Энэ мэдээллийг Кувейт Улсын Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Зөвлөлд 2010, 2015 оны Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлтийн үед хүргүүлсэн тайлан болон тус улсын ЭЯГБХУТК/CEDAW-д хүргүүлсэн тайлангаас авсан (2021).

36 A/HRC/WG.6/34/ITA/1.para45.

Төсөв батлах

Хүн бүр эрхээ эдэлж байх баталгааг хангах, хүний эрхийн чиглэлээр хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө санхүү шаардлагатай. Улсын төсвийг баталж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо парламент хүний эрхийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв санхүү батлагдсан байхад анхаарах ёстой. Дараа нь засгийн газрын зардалд мониторинг хийхдээ парламент шаардлагатай гэж үзвэл хүний эрхийн чиглэлээр хангалтгүй ажилласан бол засгийн газартай хариуцлага тооцох хэрэгтэй.

Парламентын хяналт

Парламент гүйцэтгэх засаглалын бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих чадвараа бэхжүүлэх хэрэгтэй. Хяналтын үр дүнтэй системийг бий болгохын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

- Гүйцэтгэх засаглалын хариуцлагын тогтолцоог хангахад хүчтэй эрх мэдэл, тодорхой заасан чиг үүрэг бүхий хүний эрхийн асуудлаарх Парламентын хяналтын хороог байгуулах
- Хорооны сонсголыг зохион байгуулах, сайд нар, төрийн албан хаагчид болон бусад гүйцэтгэх засаглалын албан тушаалтнуудаас бичгээр асуулга авах
- Баримт нотолгоо бүрдүүлэх, эсхүл эрэн сурвалжлах зөвлөл юм үү хороог байгуулах
- ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг хүний эрхийн чиглэлээр ажилладаг холбогдох талуудтай хамтран ажиллах
- зөрчил гарах магадлал өндөр газруудад газар дээр нь очиж ажиллах (шорон, цагдаа, дүрвэгсдийн хуаран гэх мэт)
- өөрсдийн хяналтын үйл ажиллагаанд олон улсын хүний эрхийн механизмын зөвлөмжийг тусгаж ажиллах

2018 онд Узбекистан Улсын Дээд ассемблей хүний эрхийг хамгаалах, НҮБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх парламентын хяналтын механизмыг байгуулсан. НҮБ-ын хүний эрхийн механизмтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө батлан гаргаж, парламентын хүний эрхийн тайланг анх удаа хэвлэн гаргасан байна.

Парламентын гишүүдийн зүгээс сайд нар, төрийн албан хаагчид болон бусад гүйцэтгэх засаглалын албан тушаалтнуудаас амаар болон бичгээр асуулга авах, баримт нотолгоо бүрдүүлэх эсхүл эрэн сурвалжлах зөвлөл юмуу хороогоор дамжуулах, хэрэв дээрх арга амжилтгүй бол итгэл үзүүлэх эсэх санал хураах зэргээр засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой. Парламентын гишүүд эрх мэдлээ, ялангуяа хяналт тавихтай холбоотой эрх мэдлээ хэрэгжүүлэхэд тэдний хүний эрх мөн хамгаалагдсан байх шаардлагатай. ОУПХ энэхүү үүргийг Парламентын Хүний эрхийн хороонд даалгасан бөгөөд хороо нь парламентын гишүүдийг ажил үүргээ гүйцэтгэхэд саад болж болзошгүй хүний эрхийн зөрчлийг хянан авч үздэг.³⁷

Бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмж, шийдвэрийн мөрөөр арга хэмжээ авах, хэрэгжүүлэх

Парламентын гишүүд НҮБ-ын гэрээний байгууллагууд, тусгай эрх бүхий этгээд, бүс нутгийн хяналтын байгууллагаас тодорхойлон гаргасан зөвлөмж болон Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлтийн үеэр улс орны хүний эрхийн талаар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой гаргасан зөвлөмжүүдийг ашиглаж болно. Түүнчлэн эдгээр зөвлөмжийг улс орны хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явдлыг сайжруулах зорилгоор хууль санаачлах, нэмэлт өөрчлөлт оруулах, батлахдаа үндэслэл болгон хэрэглэж байна. Үүнтэй адилаар тухайн улс орны хувьд харьяаллыг нь хүлээн зөвшөөрсөн бүс нутгийн хүний эрхийн асуудлаарх шүүхийн шийдвэртэй танилцаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг парламентуудад уриалдаг.

Хүний эрхийн хамгаалагчийн үүргээ бэхжүүлэх, НҮБ-д хүргүүлэх тайланд бодит хувь нэмэр оруулахын тулд парламент хүний эрхийн асуудал хариуцсан хорооны төлөөллийг уг тайланг НҮБ-д танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулах хэрэгтэй. Тэдэнд тайлагнах үйл явцын эцэст батлагдан гардаг зөвлөмжийн талаар мэдээлэл өгөх хэрэгтэй.

37 Дэлгэрэнгүй мэдээллийг ОУПХ “Парламентын гишүүдийн хүний эрхийн асуудлаарх хороо” <https://www.ipu.org/about-ipu/structure-and-governance/governing-council/committee-human-rights-parliamentarians>.

НҮБ-д тайлангаа танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд парламентын гишүүдийг оруулах

Хэд хэдэн улсын парламент НҮБ-ын механизмд тайлангаа танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд парламентын гишүүдийг оруулж эхэлсэн. Хэдийгээр энэ нь нийтлэг хэвшээгүй байгаа ч, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт болон НҮБХЭДКГ-аас үүнийг илүү системтэйгээр зохицуулахыг уриалдаг. Сүүлийн үеийн зарим жишээнээс дурдвал:

- 2017 онд Пакистаны Үндэсний ассемблейн гишүүн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөвлөлд танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон.
- 2018 онд Мексикийн Конгрессын гишүүн Хүний эрхийн зөвлөлд танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон.
- 2019 онд Сербийн парламентын гишүүн Эмэгтэйчүүдийн алагчилах бүх хэлбэрийг таслан зогсоох зөвлөлд танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон.
- 2020 онд Италийн Сенатын гишүүн болон төлөөлөгчдийн танхимын гишүүдээс Хүний эрхийн зөвлөлийн 43-р чуулганд³⁸ оролцсон бол Узбекистаны Дээд ассемблейн гишүүн Хүний эрхийн зөвлөлд танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон байна.

Хүний эрхийн асуудал хариуцсан хүчтэй, үр дүнтэй Парламентын хороог байгуулах

Хүний эрхийн асуудлыг дагнан хариуцсан Парламентын хороо байгуулах нь хүний эрхийн асуудлаар парламент ач холбогдол өгч ажиллаж буй гэсэн улс төрийн хүчтэй дохиог өгдөг. Ингэснээр хүний эрхийн асуудлууд парламентын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байнга орж байх явдлыг хангахад тустай. Парламентын хүний эрхийн албанд хууль тогтоомж нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхэд үнэлгээ өгөх, парламентын үйл ажиллагаа, журам, бүтцэд хүний эрхийн асуудлыг тусгах, засгийн газрын үйл ажиллагаанд гарч буй аливаа доголдлыг засч залруулах талаар тодорхой арга хэмжээ авах зөвлөмж батлах зэрэг олон үүрэг хариуцлага оногдуулдаг.

Парламентын үүргийг бэхжүүлэх ажлын хүрээнд Хүний эрхийн зөвлөл 35/29 тоот тогтоол батлан НҮБХЭДКГ-т парламентын үйл ажиллагааг UPR зэрэг хүний эрхийн бусад асуудалтай хэрхэн уялдуулах талаар судалгаа хийх хүсэлт гаргасан. 2018 онд НҮБХЭДКГ гишүүн орнуудын парламент, ХЭҮК-т явуулсан асуулгад улс орнуудын өгсөн хариултад дүн шинжилгээ хийж, уг тайлангаа Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн.³⁹ Тайланд парламентын хүний

38 Хүний эрхийг хангах, хамгаалах Онц бүрэн эрхэт комиссын Ерөнхийлөгч (Сенат), Хүний эрхийн байнгын хорооны Ерөнхийлөгч (Төлөөлөгчдийн танхим)

39 A/HRC/38/25

эрхийн хороо, түүний гүйцэтгэх чухал үүрэг нь Хүний эрхийн төлөв байдлын тайлангийн бүхий л үе шатанд, ялангуяа зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой болохыг тэмдэглэв. Тайлангийн хавсралтад парламент хүний эрхийн хороо байгуулах, түүний байнгын үйл ажиллагааг хангах талаар заавар өгөх зорилго бүхий “Парламент болон хүний эрхийн талаарх зарчмын төсөл”-ийг тусгажээ.

Парламентын хүний эрхийн хорооноос авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ

- Канад Улсад Хүний эрхийн асуудлаарх Сенатын Байнгын хороо хүний эрхийн тодорхой асуудлыг онцлох, бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж гаргах зорилгоор нарийвчилсан хэд хэдэн судалгаа хийжээ. Үүнд Канадын хууль тогтоомж дахь олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах арга хэрэгслийн үр нөлөөний судалгаа (2011-2012), шоронгийн нөхцөл байдлын судалгаа (2017-2019).
- 2016 онд Уганда Улсын Парламентын Хүний эрхийн хороо парламентын шийдвэрлэсэн хууль, тогтоомж, өргөдөл, бодлогын баримт бичиг, төсөв болон бусад үйл ажиллагаан дахь нийцэлгүй байгаа зохицуулалтыг илрүүлэхэд парламентын гишүүдэд зориулсан практик заавар бүхий хүний эрхийн асуудлаарх шалгах хуудас (checklist) боловсруулжээ. Парламентын бүх хороод энэхүү шалгах хуудсыг ашиглан хуулийн төсөл болон бусад үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, хүний эрхийн талаарх хүлээсэн үүрэгт нийцэж буй эсэхийг хянадаг.

Хуулийн төсөл боловсруулахад иргэний нийгмийн оролцоог хангах

Парламент болон иргэний нийгэм хамтран ажилласнаар харилцан ашигтай байна. Үүний тулд, парламент ба иргэний нийгэм нь харилцан адилгүй боловч олон талаараа харилцан биенээ нөхөх чиг үүрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Олон парламент болон хороод нь үйл ажиллагаагаа нийтэд нээлттэй болгосон бөгөөд саналаа ирүүлэх, гаднаас мэргэжилтэн ирж мэдүүлэг өгөхийг урьдаг болсон. Парламент нээлттэй сонсгол хийх замаар иргэний нийгэмд илүү хүрч ажиллах болсон. Иргэний нийгмийн байгууллагууд парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад тодорхой асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт өгнө. Парламентад тодорхой асуудлаар хууль тогтоомжийн судалгаа хийх чадавхи дутмаг байх тохиолдолд эдгээр санал дүгнэлт, хувь нэмэр маш чухал үүрэгтэй байна. Түүнчлэн, иргэний нийгмийн зүгээс парламентын хэлэлцүүлэгт орсноор үзэл бодлын тэнцвэрт байдлыг хангах, шинэ сэргэг үзэл, хандлагын үүднээс асуудалд хандах боломжийг олгодог.

Парламент иргэний нийгэмд хүрч, хамтран ажиллаж буй жишээнүүд

- Гүрж Улсад шашинг харилцан хүлээн зөвшөөрөх явдлыг хангах зорилгоор 2017 оны 11-р сард Гүрж Улсын парламент, шашны байгууллага, дипломат алба, дээд боловсролын байгууллага болон засгийн газрын гишүүдийн төлөөлөл хамтран Энх тайвны бага хүрлын шашин хоорондын харилцан зөвшилцлийн хэсэгт орсон байна. Дараагийн жилүүдэд ийм 2 бага хурал болсон бөгөөд 2019 онд Европын нэгдэлд Гүржийн шашны үүрэг хэмээх тунхагийг баталсан байна.
- 2019 оны 11-р сард Хорват Улсын парламентын гишүүд Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн гадуурхлыг таслан зогсоох олон улсын өдрийн хүрээнд парламентын жендэрийн тэгш байдлын хорооноос зохион байгуулсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх кампанит ажилд нэгдэв. Тухайн сард иргэний нийгэмтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд 2020 оны 1-р сард энэ хэлэлцүүлгийг парламентын гишүүдтэй хийжээ. Тухайн үед гарсан хэд хэдэн санал цааш дамжин улмаар батлагдсан байна.⁴⁰

Хүний эрхийн үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах

ХЭҮБ нь засгийн газар болон/ эсхүл парламентаас байгуулагддаг бие даасан байгууллага бөгөөд үндэсний хэмжээнд хүний эрхийг хангах, хамгаалах ажлыг удирдан зохион байгуулна. Эдгээрт олон талын байгууллагууд (хүний эрхийн үндэсний комисс, омбудсмен, хүний эрхийн хамгаалагч гэх мэт) багтах ба харилцан адилгүй нэртэй, эрх зүйн статустай, бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг ба эрх мэдэлтэй байдаг. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн холбооны гишүүний хувьд Парисын тунхагийг⁴¹ дагаж биелүүлж буй байдалд тэдгээрийн үйл ажиллагаанд тодорхой хугацаанд үнэлгээ хийдэг. ХЭҮБ-үүд “А статус” авахын тулд хараат бус бие даасан байдал, эрх мэдэл, санхүүжилт, бүрэлдэхүүн, сонгон шалгаруулах, томилох үйл явцын хувьд эдгээр зарчмын зайлшгүй дагаж мөрдөж стандартыг хангаж байх шаардлагатай. 2012 оны Белградын зарчим⁴² нь парламент ба ХЭҮБ-ын хоорондын хамтын ажиллагааны талаар⁴³ удирдамж, заавар өгдөг.

ХЭҮБ нь хүний эрхтэй холбоотой ямар ч асуудлаар засгийн газар болон парламентад зөвлөмж өгөх, санал гаргах, тайлангаа өргөн мэдүүлэх; үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандарттай нийцүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих; хүний эрхийн зөрчлийн талаар

40 A/HRC/WG.6/36/HRV/1.

41 A/RES/48/134.

42 Белградын семинарыг НҮБХЭДКГ, ХЭҮБ-ын олон улсын зохицуулах хороо, Сербийн Үндэсний ассемблей, Сербийн Бүгд найрамдах Улсын иргэдийн хамгаалах байгууллагаас хамтран Серб дэх НҮБ-ын төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан

43 Илүү мэдээллийг ХЭҮБ ба парламенттай хамтран ажиллах харилцаа НҮБХЭДКГ, “НҮБ хүний эрх ба ХЭҮБ”-аас харна уу. https://www.ohchr.org/EN/Countries/NHRI/Pages?NHRI_Main.aspx.

хувь хүний болон бүлэг хүмүүсийн гомдлыг хүлээн авах; олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг батлах хэрэгжүүлэх явдлыг дэмжих; олон улсын хүний эрхийн гэрээний дагуу тайлан боловсруулж тайлагнахад хувь нэмрээ оруулах; мэдээлэл, боловсролоор дамжуулан хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах; хүний эрхийн асуудлаар судалгаа хийх, НҮБ, бүс нутгийн болон бусад улсын ижил төрлийн байгууллага болон ТББ-уудтай хамтран ажиллах чадамжтай, эрх мэдэлтэй байх шаардлагатай.

Парламент ба ХЭҮБ хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа

2019 оны 12-р сард Морокко Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон Морокко Улсын Парламент хамтран Хүний эрхийн төлөв байдлын дүгнэлтийн зөвлөмжийн талаарх парламентын гишүүдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, түүний хэрэгжилтэд мониторинг хийх парламентын үүрэгтэй холбоотой зарим асуудлыг хэлэлцэхээр уулзалт семинарыг зохион байгуулав.⁴⁴ Семинарыг хоёр байгууллагын хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд⁴⁵ зохион байгуулсан ба хүний эрхэд суурилсан хандлагын зарчмаар хамтран ажиллах, хүний эрхийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, соёрхон батлахаар яригдаж буй олон улсын хүний эрхийн гэрээний үр нөлөөний асуудлаар ХЭҮК-той зөвшилцөх зэрэг асуудлыг тусгасан.

Парламентын гишүүдийг хүний эрхийн асуудлаар чадавхжуулах

Парламентын гишүүдэд хүний эрхийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах нь чухал. ОУПХ, НҮБХЭДКГ-аас парламентаар зориулсан техникийн хамтын ажиллагаа, чадавх бэхжүүлэх туслалцааг олон жилийн туршид үзүүлсээр ирсэн. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь парламентын гишүүдийн олон улсын хүний эрхийн механизмын үйл ажиллагааны талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, хүний эрхийг хангах, хамгаалах талаар парламентаас авах тодорхой арга хэмжээг тодорхойлоход чухал байдаг. Эдгээр үйл ажиллагаа нь парламентын гишүүдийн улс төрийн харьяаллаас үл шалтгаалан бүгдийг нь хамруулах ба парламентын хүний эрхийн хороо болон бусад холбогдох хорооны гишүүдийг оролцуулах шаардлагатай. Парламентын гишүүдийг чадавхжуулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах явдлыг дэмжихэд парламентын удирдлагын дэмжлэг маш чухал.

44 Милун Котари, Хүний эрхийн төлөв байдлын дүгнэлттэй холбоотой шинэ сайн туршлагын талаарх судалгаа, (Женев хот, НҮБХЭДКГ 2021) https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/UPR/emerging_UPR_GoodPractices.pdf.

45 2021 оны 6-р сарын 10-ны өдөр Мороккогийн Парламент ба ХЭҮК хооронд Харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, ХЭҮК ба Парламент хоорондын харилцааг Парисын Тунхаг болон Белграддын зарчимд тусгасны дагуу зохицуулж, ХЭҮК-ийн бие даасан үйл ажиллагааны талаар тусгасан. Илүү мэдээллийг Мороккогийн Хаант Улс, Хүний эрхийн үндэсний комисс “ХЭҮК болон Төлөөлөгчдийн танхимын хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулах нь”-аас харна уу. <https://www.cndh.ma/an/article/amendment-and-updating-memorandum-understanding-between-cndh-and-house-representatives>.

Олон улсын хүний эрхийн механизмын үйл ажиллагаан дахь Парламентын оролцоо

Хүний эрхийн зөвлөлийн 35/29 тоот тогтоол нь парламентын хүний эрхийг хангах, хамгаалах талаарх стратегийн түнш болох чухал үүргийг хүлээн зөвшөөрсөн. Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн бүхий л механизмд идэвхтэй, санаачлагатай оролцсоноор, парламентын үүрэг хариуцлага ялангуяа үндэсний хэмжээнд улам бэхжинэ.

Эдгээр механизмын үйл ажиллагаанд парламентын оруулах хувь нэмэр яагаад чухал вэ?

Өмнө дурдсанчлан, Хүний эрхийн зөвлөл болон гэрээний байгууллагуудын баталсан зөвлөмжийг хэрэгжүүлж амь оруулахад парламентаас авах арга хэмжээ шаардлагатай байдаг. Парламент нь хүний эрхийн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний эрхийн мэдрэмжэй хууль тогтоомжийг батлах зэргээр аливаа байгаа хийдлийг арилгахад хувь нэмэр оруулах боломжтой байдаг.⁴⁶

Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хороо ба парламент

Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хороо нь НҮБ-ын гэрээний байгууллагууд дотор парламент болон ОУПХ-той хамтран ажиллах бодлого баталсан цорын ганц байгууллага юм.⁴⁷ 2008 онд тус хороо конвенцийн заалтыг хэрэгжүүлэх болон тайлагнах үйл явцад парламент оролцохын чухал болохыг гишүүн орнуудын анхаарлыг хандуулах зорилгоор тайланг нь дүгнэж буй бүх улсын дүгнэлт ажиглалтад “Парламент” гэсэн хэсгийг системтэйгээр стандарт болгон тусган оруулж байхаар шийдсэн. Конвенцийг соёрхон баталсан улс орнууд Конвенцийн заалтын хэрэгжилтийг хэр хангаж ажилласнаа үнэлэх дотоод үнэлгээг хийсний дараа тус Зөвлөлд дөрвөн жилд нэгээс доошгүй удаа тайлагнах үүрэгтэй. ОУПХ тус хороотой хамтран парламентуудыг улс орны тайланг боловсруулах, танилцуулахад болон дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцохыг дэмжин ажиллаж байна.

46 A/HRC/38/25. 28 дахь хэсэг

47 НҮБХЭДКГ, “Үндэсний парламент ба Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг таслан зогсоох тухай Конвенци” <https://www.ohchr/Documents/HRBodies/CEDAW/Statements/Parliaments.pdf>.

Олон улсын хүний эрхийн механизмд тайлагнах, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл явцын гурван үе шатанд парламент ямар үүрэг гүйцэтгэх вэ?

Улс орны тайлангийн талаар зөвшилцөх, тайланг боловсруулахад оролцох

Хүний эрхийн зөвлөл 35/29 тоот тогтоолдоо улс орнуудыг үндэсний тайланг боловруулахдаа холбогдох талуудтай зөвшилцөх үйл явцыг өрнүүлэхэд парламентыг оролцуулахыг дэмжиж ажиллахыг уриалсан. Парламент олон улсын хүний эрхийн байгууллагад танилцуулах тайланг хэлэлцэх тусгай чуулган зарлан хуралдуулж болох ба хүний эрхийн тодорхой асуудлаар тайланд оруулах саналаа бичгээр өгөх боломжтой.

2020 оны 2-р сард өргөн мэдүүлсэн Хорват Улсын Хүний эрхийн төлөв байдлын 3 дахь тайлан нь засгийн газрын холбогдох бүх талууд, ИНБ, болон Хорватын Парламентын оролцоог хангасан үйл явцын үр дүнд боловсруулагдсан. Түүнчлэн, НҮБ-ын гэрээний байгууллагуудад хүргүүлдэг тайланд мониторинг, дүгнэлт гаргадаг парламентын Хүний болон цөөнхийн эрхийн асуудал хариуцсан хороо нь Хүний эрхийн төлөв байдлын дүгнэлтийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд оролцдог.

Үндэсний тайланг олон улсын хүний эрхийн байгууллагад танилцуулах нь

НҮБ-ын өмнө тайлангаа танилцуулах үндэсний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд парламентын төлөөлөл мөн оролцох боломжтой. Ийнхүү оролцсоноор наад зах нь олон улсын хүний эрхийн байгууллагуудаас тавьж буй асуулт, улс орны төлөөлөгчдийн өгч буй хариултыг шууд, газар дээр нь сонсч мэдээлэл авна. Зарим орны хувьд парламентын гишүүд улсынхаа тайланг танилцуулах болон НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудтай түүний мөрөөр харилцахад шууд, зарим үед манлайлан, оролцдог.

Олон улсын хүний эрхийн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Олон улсын хүний эрхийн механизмын амжилт нь тэдний өгч буй зөвлөмжийг улс орнууд хэр түвшинд хэрэгжүүлэхээс ихээхэн хамаарна. НҮБ-ын гэрээний байгууллагууд болон Хүний эрхийн зөвлөлөөс томьёолон гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүний эрхийн талаар хүлээх үүргээ биелүүлэх талаар засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавихад парламентууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

2014 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний ассемблей Эмэгтэйчүүдийн хөгжлийн тухай суурь хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэчилсэн хувилбарыг баталсан. Дараа нь уг хуулийг Жендэрийн тэгш байдлын тухай хууль гэж нэрлэх болсон. Хуулийн 40.5-р зүйлд Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн гадуурхлыг таслан зогсоох НҮБ-ын зөвлөлд танилцуулах Засгийн газрын тайланг эхлээд Үндэсний ассемблейд өргөн мэдүүлэхээр заасан байна.

Хүний эрхийн Зөвлөлд тайлагнах үйл явцын гурван үе шатанд идэвхтэй оролцох

2018 оны 5-р сард Хүний эрхийн зөвлөл Женев хотноо хуралдахдаа Узбекистан Улсын тайланг авч хэлэлцсэн. Тухайн сарын сүүлээр Зөвлөлийн зөвлөмжийн талаар парламентын гишүүдэд танилцуулах хурал Узбекистанд болов. Зөвлөмжийг 2018 оны 9-р сард хүлээн зөвшөөрч, Узбекистаны Дээд ассемблейд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Парламент зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн Үндэсний хэмжээний Үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх үйл явцад оролцсон.

Хүний эрхийн асуудлаар өөрийн үнэлгээ хийхэд бэлтгэх

Үнэлгээний зорилго ба хэрэглээ

ОУПХ-ны туршлагаас харахад сайтар боловсруулсан асуулт, аргачлал нь парламентын хувьд тэргүүлэх чиглэлээ тогтоож, сорилтуудаа тодорхойлох мөн нөхцөл байдалд тохирсон шийдлийг олох талаар хэлэлцэх боломж олгох өргөн хүрээний хэлэлцүүлгийг өрнүүлдэг байна.

Нөхцөл байдал болон оролцогч холбогдох талуудаас шалтгаалан энэхүү аргачлалыг олон арга хэлбэрээр ашиглаж болно. Тухайлбал, парламент хүний эрхийн мэдрэмжийг парламентын хэмжээнд хангах, парламентын гишүүдийг хүний эрхийн гол асуудлын талаар хэлэлцэх эсхүл хууль тогтоомжийг хүний эрхийн өнцгөөс дүгнэдэг болгох зэрэгт энэ аргачлалыг хэрэглэх боломжтой.

Нөхцөл байдлаас шалтгаалан аргачлалыг хэрэглэх тодорхой хэрэглээ нь харилцан адилгүй байх боломжтой ч аргачлал нь дараах гурван үндсэн зорилготой байна. Үүнд:

- Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, байгууллага, тэдний зөвлөмжийн талаар парламентын түвшинд хэр мэдээлэлтэй байна, парламентын үйл ажиллагаа, журам, бүтэц тогтолцоонд хэрхэн үялдүүлж байгааг үнэлэх;
- Сайн туршлага, хийдэл, сургамжийг тодорхойлох;
- Парламент хүний эрхийн талаар илүү мэдлэг ойлголттой байж, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах чиглэлээр арга хэмжээ авах нөхцөлийг хангах;

Өөрийн үнэлгээний эхлэл болгон энэ аргачлалыг ОУПХ болон НҮБХЭДКГ-ын хэвлүүлсэн *Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага №26*.⁴⁸-тай хамтад нь хэрэглэж болно. Дараа нь парламент шаардлагатай буюу хэрэгцээтэй гэж үзвэл хэдэн ч удаа өөрийн үнэлгээг хийж болно. Энэ аргачлалыг парламентын аль нэг гишүүн, парламентын хороо, эсхүл парламентын ажлын албаны ахлах албан тушаалтны санал болгосноор тохиромжтой гэж үзсэн хэдийд ч хийж болно. Гэвч өөрийн үнэлгээг төгсгөл гэж харж болохгүй, харин үрт хугацаанд үр дүн нь гарах эхлэл гэж ойлгоно.

48 Хүний эрхийн талаар илүү мэдээллийг ОУПХ, НҮБХЭДКГ. Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага №26-аас харна уу.

Өөрийн үнэлгээ үр дүнтэй байх эсэх нь парламентын зүгээс хүний эрхийн талаар мэдлэг ойлголтыг сайжруулах талаар авч буй арга хэмжээ, хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоомж батлах, эдгээр стандартад нийцэхгүй байгааг нь хүчингүй болгох, хяналтын үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх, хүний эрхийн асуудлыг үйл ажиллагаандаа тусгах, НҮБ-ын хүний эрхийн тайлагнах үйл явц дахь оролцоогоо нэмэгдүүлж байгаа эсэхээр хэмжигдэнэ.

Энэхүү аргачлалд тусгагдсан асуултууд нь парламентыг тэргүүлэх чиглэлээ тогтоож, үйл ажиллагааны чиглэлийг сонгох боломжийг олгодог. Тухайлбал, өөрийн үнэлгээ хийх нэг дасгалын хувьд 1-2 асуултыг сонгох эсхүл тодорхой асуудал дээр ямар ахиц дэвшил гарсанд голлон анхаарч сайн түршлага болон авсан сургамжийг тодорхойлж болно.

Парламент энэ аргачлалыг нөхцөл байдал, онцлогтоо тохируулан өөрчлөн ашиглах болон тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр ашиглах нь зүйтэй.

Удирдлагын дэмжлэг

Өөрийн үнэлгээ нь сайн дурын үндсэн дээр хийх ажил бөгөөд парламентыг үнэлэх, байр эзлүүлж жагсаахыг зорьдоггүй. Харин парламент хүний эрхийн чиглэлээр ахиц, үр дүн гаргаж ажиллах үүргээ бэхжүүлэхийн тулд тэргүүлэх чиглэлээ тогтоож, сорилт ба боломжуудаа тодорхойлоход туслах зорилготой юм. Ийнхүү өөрсдийгөө дотроосоо ажиглаж, дүгнэх дасгал нь парламентын удирдлагын зүгээс дэмжиж, үйл явцыг нь баталснаар илүү үр дүнтэй байна. Сайн дураар өөрийн үнэлгээ хийх дасгал нь үнэлгээний үр дүн, дүгнэлтийн талаар парламент өөрөө илүү мэдэж, эзэн нь байх боломжийг олгоно.

Өөрийн үнэлгээний зорилтот бүлэг нь парламентын гишүүд, парламентын ажлын албаны ажилтнууд, ялангуяа парламентын хүний эрхийн хорооны гишүүд байна. Үнэлгээний үйл явцыг эхлүүлэхээс өмнө оролцогч талууд парламентын хууль тогтоох, төлөөлөх болон хяналтын зэрэг чиг үүргийн хувьд сайжруулах шаардлагатай, анхаарах асуудал, тэргүүлэх чиглэлийг тодорхойлохын тулд одоогийн нөхцөл байдлыг дүгнэж, энэ талаар нэгдсэн ойлголтод хүрсэн байх хэрэгтэй.

Тэгш хамруулах, гардан хариуцах

Өөрийн үнэлгээ нь олон талын оролцоог хангасан эсэхээс шалтгаалж албан ёсны байх эсэх нь хамаардаг хамтын ажиллагаа юм. Эрх баригчид болон цөөнхийн төлөөлөл, эрэгтэй ба эмэгтэй гишүүд, ахмад ба залуу гишүүд, үндэсний цөөнхийн төлөөлөл гэх мэт олон тал үзэл бодлоо илэрхийлэх орон зайг бүрдүүлсэн байх хэрэгтэй. Оролцогчид нь харилцан адилгүй бүлгийн төлөөлөл байснаар олон талын байр суурь, үзэл бодлыг илэрхийлж, үнэлгээ бүтээлч болоход нөлөөлнө. Үнэлгээний явцад авч үзэх тодорхой зарим асуудлын хувьд өөр байр сууринаас хандах парламентын ажлын албаны ахмад ажилтнуудыг оролцуулах нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Нөхцөл байдалдаа тохируулан ажилтнуудыг хамгийн үр дүнтэйгээр хэрхэн оролцуулах вэ гэдгийг парламент шийдэх хэрэгтэй. ХЭҮК-ийн гишүүд, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээлэл, эмэгтэйчүүдийн бүлэг, залуучууд, практик ажилтнуудын бүлгийн төлөөлөл гээд бусад оролцогчдыг мөн энэхүү өөрийн үнэлгээнд оролцуулж болно. Хөндлөнгийн оролцогчдын туршлага, үзэл бодол нь үнэлгээний үйл явцыг илүү баяжуулна. Парламент энэ хэлбэрийг сонгох эсэхээ шийдэх боломжтой байна.

Өөрийн үнэлгээг зохион байгуулах

Өөрийн үнэлгээний үр дүн сайн байх нь бэлтгэл ажил, ашиглах боломжтой мэдээллийн эх сурвалж, өндөр түвшиний улс төрийн дэмжлэгээс ихээхэн шалтгаална. Ихэвчлэн, өөрийн үнэлгээ нь парламентын удирдлагын түвшний, өөрөөр хэлбэл Спикер юм уу байнгын хорооны даргын удирдлага дор багаараа зохион байгуулсан тохиолдолд илүү үр дүнтэй болдог.

Өөрийн үнэлгээ хийсний дараа: хэрэгжүүлэх ба авах арга хэмжээ

Өөрийн үнэлгээгээр илрүүлсэн асуудал, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахыг дэмжихийн тулд холбогдох эрх бүхий этгээд, оролцогч талуудтай эдгээр мэдээллийг хуваалцах хэрэгтэй. Үүний нэгэн адил, парламент өөрийн үнэлгээний үр дүнд гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргах зэрэгт засгийн газар, ХЭҮК, иргэний нийгэм, хөгжлийн байгууллагуудтай хамтарч ажиллаж болно. Парламент шинээр үнэлгээ хийхээс өмнө үрд нь хийсэн өөрийн үнэлгээний зөвлөмжийн талаар хэлэлцэн, хэрэгжилтийн байдлыг дүгнэх нь үр дүнтэй.

Өөрийн үнэлгээний шалгах хуудас

Парламентын өөрийн үнэлгээний бэлтгэл

Удирдлагын дэмжлэг	<ul style="list-style-type: none">• Парламентын удирдлагаас хүний эрхийн асуудлаар өөрийн үнэлгээ хийх процессыг баталсан уу?
Санаачлага	<ul style="list-style-type: none">• Хэн, эсхүл юу энэ үнэлгээг санаачлах буюу зохион байгуулах вэ?
Зорилго	<ul style="list-style-type: none">• Энэ үнэлгээний зорилго юу вэ?• Үнэлгээний ач холбогдол, зорилгын талаар Парламентын гишүүд болон бусад оролцогчдын дунд нэгдсэн ойлголт бий болсон эсэх?
Зохион байгуулалт	<ul style="list-style-type: none">• Энэ ажлын зохион байгуулалтын асуудлыг хэн хариуцаж хийх вэ?• Өөрийн үнэлгээ хийхэд шаардлагатай санхүү төсөв байна уу?• Өөрийн үнэлгээний үйл явцыг эхлүүлэхээс өмнө танилцуулах сургалт семинар зохион байгуулах уу?
Оролцоо	<ul style="list-style-type: none">• Үнэлгээнд хэн хэн оролцох вэ?• Оролцох парламентын гишүүдийг хэрхэн сонгох вэ? Сонирхож буй парламентын гишүүд бүгдийг нь урих уу эсхүл цөөн хэсгийг төлөөлөл болгож урих уу?• Парламентын ажлын албаны ажилтнуудыг оролцуулахаар урих уу?• Үнэлгээ нь хүний эрхийн зөвлөлийн гишүүдэд зориулагдсан уу?• Гадны холбогдох талууд идэвхтэй оролцогч байдлаар эсхүл мэргэжилтэн экспертийн хувьд оролцох уу? Эдгээр хүмүүсийг хэрхэн сонгох вэ?
Чиглүүлэх	<ul style="list-style-type: none">• Өөрийн үнэлгээг хэрхэн чиглүүлэх вэ? Үнэлгээний бүх үйл явцад нийтэд нь чиглүүлэх нэг чиглүүлэгч байх уу?• Гадны чиглүүлэгч байх уу? Хэрэв тийм бол, энэ гадны чиглүүлэгч хэн байх вэ?• Чиглүүлэгчийг хэрхэн сонгож, энэ талаар санал нэгдэх вэ? Тэдэнд ямар дэмжлэг хэрэгтэй вэ?• Чиглүүлэгч авч ажиллуулахад төсөв санхүү хэрэгтэй юу эсхүл түнш байгууллага энэ үүргийг гүйцэтгэх үү?

Хугацаа	<ul style="list-style-type: none"> • Өөрийн үнэлгээг хэзээ хийх вэ? • Энэ ажил хэдий хугацаанд үргэлжлэх вэ? (хугацаа нь өдрөөр эсхүл уулзалтаар хэмжигдэх үү)
Баримт мэдээллийн эх сурвалж	<ul style="list-style-type: none"> • Өөрийн үнэлгээнд мэдээлэл болох ямар баримт мэдээлэл байна вэ? Үүнд: <ul style="list-style-type: none"> - Ашиглах боломжтой засгийн газрын тайлан мэдээ? - Бэлэн байгаа парламентын болон холбогдох хороодын тайлан? - Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудын холбогдох тайлан? - ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагуудын тайлан?
Баримтжуулах үйл явц	<ul style="list-style-type: none"> • Энэ ажилд илтгэгч танилцуулагч байх хэрэгтэй юу?
Үнэлгээний үр дүн	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний хүлээгдэж буй үр дүн юу вэ, жишээ нь үнэлгээний тайлан болон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах үү (эсхүл аль аль нь үү), хүний эрхийн үндэсний механизмын гол оролцогч талууд, түншлэгчдийн жагсаалт байх үү? • Эдгээр үр дүнг гаргах үүргийг хэн хүлээх вэ (жишээ нь парламентын Тамгын газар үү, хороод үү)?
Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний мөрөөр юу хийхээр төсөөлж байгаа вэ? Хэзээ? • Үнэлгээний мөрөөр хийх ажлыг хэн хариуцах вэ? • Үнэлгээний мөрөөр хийх ажилд хэн мониторинг хийх вэ?

Өөрийн үнэлгээний асуултууд

Дараах хэсэгт байгаа асуултууд нь парламентын гишүүдэд өөрсдийгөө бэлэн эсэхийг шалгах, улс орныхоо нөхцөлд тохирсон, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тэргүүлэх чиглэлээ тодорхойлоход туслах зорилготой юм. Тиймээс эдгээр асуултууд нь хэд хэдэн парламентын төлөөлөлтэй хийсэн уулзалт, хүний эрхийн асуудлаарх асуулгад өгсөн тэдний хариулт зэрэгт үндэслэсэн тодруулах (indicative) асуултууд байна.

Багц асуулт бүр хоёр хэсгээс бүрдэнэ. А хэсгийн асуултууд нь гол төлөв баримт мэдээлэлд суурилсан ба В хэсгийн асуултууд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чиглэх ярилцлагын суурь болох зорилготой юм.

Парламент бүх асуултуудыг заавал хэлэлцэх шаардлагагүй. Түүнчлэн өөрийн улс орны нөхцөл байдалд тохируулан асуултуудыг нэмэх боломжтой.

Асуулт 1: Парламентын түвшинд хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх

Хүний эрх гэж юу болох, парламентын эрх мэдлийг үндэсний хэмжээнд хүний эрхийг хангах хамгаалахад хэрхэн ашиглах талаар илүү сайн ойлголт, мэдлэгтэй байх нь парламентын гишүүдийг өөрсдийн үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжтой болгоно. Тиймээс парламент нь хүний эрхийн талаарх мэдээлэл бүх гишүүд болон ажилтнуудад нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг хангах хэрэгтэй. Тухайлбал, хүний эрхийн үндсэн зарчим, гэрээнүүдийн талаар мэдээллийн семинарыг тогтмол зохион байгуулах, парламентын номын санд хүний эрхийн талаарх нийтлэл, хэвлэлүүдийг байлгах гэх мэт.

А хэсэг: Суурь түвшингээ тодорхойлох

- Одоогийн болон шинээр сонгогдсон парламентын гишүүд олон улсын хүний эрхийн гэрээ, механизм зэрэг хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй байна уу?
- Шинээр сонгогдсон парламентын гишүүдэд сонгуулийн дараа олон улсын хүний эрхийн гэрээ, механизм зэрэг асуудлын талаар танилцуулсан уу?
- Парламентын гишүүд хүний эрхийн асуудлаар чадавх бэхжүүлэх арга хэмжээ (олон улсын, бүс нутгийн болон олон улсын)-нд хамрагдах боломжтой юу?

- Парламентын гишүүд парламентын номын сангаас мэдээлэл авах боломжтой байдаг уу? Олон улсын хүний эрхийн талаарх гол механизм, тэдгээрийн зөвлөмжийн талаар мэдээлэл авах боломжтой байдаг уу?
- Парламентын ажлын албаны ажилтнууд, ялангуяа хүний эрхийн талаар нөлөө үзүүлэх боломж бүхий ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд, хүний эрхийн талаар мэдлэгтэй байна уу? (олон улсын хүний эрхийн гэрээ болон механизмууд гэх мэт)

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад зориулсан хүний эрхийн асуудлаар сургалт, семинар зохион байгуулсан уу? Хэрэв тийм бол, хэдэн арга хэмжээ зохион байгуулагдсан ба парламентын хэдэн гишүүн, ажлын албаны хэдэн ажилтнууд (эрэгтэй, эмэгтэй) хамрагдсан бэ?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламентын гишүүд хүний эрхийн талаарх боломжит мэдээллийг бүрэн ашиглаж, суралцаж чаддаг уу?
Хэрэв ийм боломж байгаа бол парламентын гишүүд парламентын сургалтад элсэх, хүний эрхийн асуудлаарх хөтөлбөр бүхий ямар нэг хэлбэрийн сургалтад хамрагдсан уу?
- Парламент, ХЭҮК, иргэний нийгэм болон хүний эрхийн асуудлаар ажилладаг бусад эрх бүхий байгууллагад хандаж, хүний эрх, олон улсын хүний эрхийн механизмын асуудлаар мэдээлэл өгөх, парламентын гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах хүсэлт гаргасан уу?
- Хүний эрхийн талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулахтай холбоотойгоор парламентын номын санг сайжруулах хэрэгцээ байгаа эсэхийг парламент авч үзсэн үү? Хэрэв тийм бол, үр дүнд хүрэхүйц шаардлагатай алхмыг авч хэрэгжүүлсэн үү?

Асуулт 2: Хүний эрхийг дэмжих талаар хууль тогтоомж гаргаж байгаа юу?

Хүний эрхийн талаар мэдлэгтэй байх нь парламентыг өөрийн гол чиг үүргийн нэг болох хүний эрхийн гэрээ, зарчимд нийцсэн хууль тогтоомж батлах үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн олон улс оронд парламент хүний эрхийн гэрээг соёрхон батлах гол үүрэгтэй байдаг ба тиймээс хүний эрхийг хангах, хамгаалах явдлыг бэхжүүлэхэд мөн чухал үүрэгтэй. Олон улсын хүний эрхийн гэрээ нь үндэсний хууль тогтоомжийн хэсэг болдоггүй улс орны хувьд парламент нь гэрээний заалтуудыг хууль тогтоомждоо хангалттай тусгах үүрэгтэй. Парламент хүний эрхийг сахин хамгаалах, хуулийн үр нөлөөний үнэлгээ хийх, парламентын журмыг боловсруулах зэргээр хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоомж батлах замаар хүний эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм журамтай болсноор парламент олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн холбогдох стандартад нийцэхгүй байгаа хуулийг олж тогтоох, улмаар тэдгээрт шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулахад чухал нөлөөтэй байна. Парламент ХЭҮК-ын эрх мэдэл, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх зэргээр хүний эрхийг хамгаалах үр дүнтэй систем бий болгох эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд манлайлах үүрэг гүйцэтгэх боломжтой.

А хэсэг: Суурь үзүүлэлтээ тодорхойлох

- Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үнэлж дүгнэх эсхүл эрх зүйн шинэчлэлийг санаачлах эрх парламентад бий юу?
- Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн нэмэлт протоколуудыг засгийн газар соёрхон баталсан эсэхийг парламент тогтмол үнэлж дүгнэдэг үү? Хэрэв тийм бол, тухайн улс эдгээр олон улсын механизм, арга хэлбэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа алхмыг хийсэн үү?
- ХЭҮК байдаг уу? Хэрэв ХЭҮК байдаг бол өнөөгийн байдлаар Парисын тунхаглалыг хэр хэмжээнд дагаж мөрдөж байгаа вэ?
- Улс орны эрх зүйн тогтолцоо, үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь ардчилсан орон зайг хэр хангалттай хамгаалж, иргэний нийгмийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжоор хангадаг вэ?
- Парламент аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгүүдийн талаар болон эрх тэгш байдал, үл алагчилах эрхийг хамгаалахтай холбоотой системийн сорилтуудын талаар мэддэг үү?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламент хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, мөн бүс нутгийн/ олон улсын хүний эрхийн гэрээг баталсан үү? Хэрэв ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол эдгээр нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан үү?
- Хүний эрхийн тухай гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан үү?
- Парламент эмзэг бүлгийн иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилготой хууль тогтоомжид үнэлгээ хийх эсхүл баталсан үү?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламентад өргөн барьсан хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад хүний эрхийн асуудлаар улс орны хүлээсэн үүргийг хангалттай тусгасан эсэх талаар дүгнэлт хийсэн үү?
- Парламент олон улсын хүний эрхийн тухай гэрээний заалтууд үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байх нөхцөлийг хэрхэн хангадаг вэ?
 - Хүний тодорхой эрхийг хууль тогтоомжоор бүрэн сахин хамгаалахын тулд олон улсын хүний эрхийн тухай заалтууд үндсэн хуулийн хэмжээний статустай байх нөхцөлийг бүрдүүлэх талаар парламент ямар арга хэмжээ авсан бэ?
 - Үндсэн хууль болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн хүний эрхийн асуудлаарх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх талаар парламент арга хэмжээ авсан үү? хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг парламентын бүх гишүүдийн хувьд нээлттэй байсан үү?
- Парламент шаардлагатай үнэлгээ, дүгнэлт хийх, сайжруулахын тулд ХЭҮК-ийн үйл ажиллагааг зохицуулж буй холбогдох хууль эрх зүйн тогтолцоог авч хэлэлцсэн үү?
- Иргэний нийгэм чөлөөтэй, үр дүнтэй үйл ажиллагаа явуулж чадаж буй эсэхийг тодорхойлохын тулд парламент иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид үнэлгээ дүгнэлт өгч ажилладаг үү?

Асуулт 3: Парламентын хяналтыг бэхжүүлэх

Парламент нь хяналтын чиг үүргээрээ дамжуулан засгийн газрын бодлого, үйл ажиллагаа хүний эрхийг хангаж буй эсэхийг хянана. Парламентын хяналт нь олон хэлбэртэй байж болно. Тухайлбал, парламент хүний эрхэд нөлөөлж болзошгүй засгийн газрын үйлдэл, эс үйлдлийн талаар тайлбар авах асуудлаар холбогдох мэдээлэл гаргуулах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой тодорхой асуудлаар өөрөө санаачлан асуулга явуулж болно. Зарим улсуудад парламентын гишүүд хорих анги, шоронд очиж ажиллах зэргээр баримт нотолгоо илрүүлэх ажил санаачилж болдог. Хууль баталсны дараах хяналт тавих ажил нь парламентын хувьд хуулийн хэрэгжилтийн талаар мониторинг үнэлгээ хийх арга хэрэгсэл болно. Мөн засгийн газар хүний эрхийн гэрээ, конвенци, улс төрийн тунхагт нэгдэн ороогүй, соёрхон батлаагүй болон эсхүл нэгдэн орсон гэрээний тодорхой заалтыг түр зогсоох (reservation) зэрэг шалтгааны талаар парламент мониторинг, үнэлгээ хийж болно. Мөн хүний эрхийн талаарх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх мөн эдгээр нь олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагын зөвлөмжтэй уялдан нийцэж байх явдлыг хангахад дэмжлэг үзүүлж чадна.

А хэсэг: Суурь үзүүлэлтээ тодорхойлох

- Танай улсад хүний эрхийн үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги байгаа юу?
- Танай улсын Үндсэн хууль, эсхүл бусад хууль тогтоомжоор парламент нь асуулга авах, сонсгол хийх, тодруулга авах, газар дээр нь очиж үзэх зэргээр засгийн газрын хариуцлагын тогтолцоог сайжруулж чадаж байна уу?
- Парламент хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг дүгнэх, үнэлэх журам, аргачлалыг боловсруулсан уу? Үүнд тодорхой эмзэг бүлгийн хувьд ялгаварлан гадуурхлын үр нөлөөг бий болгож болзошгүй хуулиудад хийх үнэлгээ дүгнэлт мөн багтдаг уу?
- Олон улсын хүний эрхийн ямар гэрээнд танай улс нэгдэн ороогүй байгаа вэ? Танай улс нэгдэн орсон хүний эрхийн гэрээний ямар заалтуудыг түр зогсоосон байгаа вэ? Түр зогсоосон шийдвэртэй холбоотойгоор гэрээний байгууллагуудаас хийсэн сүүлийн үеийн дүгнэлт ажиглалтыг уншиж танилцсан уу?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Засгийн газар олон улсын хэмжээнд сүүлийн үед хийж буй үйл ажиллагааны талаар парламентад мэдээлэл хийсэн үү?
- Чуулганаар хүний эрхийн асуудлаар засгийн газарт асуулга тавьж, хангалттай мэдээлэл авч чадсан үү?
- Хуулийн хэрэгжилт хүний эрхийн хувьд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх асуудлыг тогтмол (чуулганаар/ хорооны хурлаар) хэлэлцдэг үү?
- Хүний эрхийн тодорхой асуудлаар парламент судалгаа хийх, асуулга явуулах, эсхүл баримт нотолгоо илрүүлэх ажлыг хийсэн үү? Хэрэв тийм бол, эдгээр ажлын үр дүн, үр нөлөө юу байв?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Хүний эрхийн үндэсний хөтөлбөр/ үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг бол, парламент түүний хэрэгжилтэд хяналт тавьж байна үү? Хэрэв ийм хөтөлбөр/ төлөвлөгөө байдаггүй бол парламентын зүгээс засгийн газрыг ийм хөтөлбөр/ төлөвлөгөө боловсруулах арга хэмжээ авах талаар зөвлөж байна үү?
- Парламент эсхүл асуудал хариуцсан хороо засгийн газрын гишүүд, холбогдох төлөөллийг (сайд нар, төрийн албан хаагчид, гүйцэтгэх албан тушаалтнууд гэх мэт) оролцуулан хүний эрхийн хөтөлбөр/ төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлын талаар мэдээлэлтэй танилцах сонсгол хийсэн үү?
- Хэрэв парламент хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг системтэйгээр үнэлж дүгнэдэг бол ямар дүгнэлт гаргасан бэ, үүнд засгийн газар ямар тайлбар өгсөн бэ? Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг үнэлэх журам, аргачлал байдаггүй бол ийм журам, аргачлалыг батлахад хүндрэл учруулж буй ямар сорилт бэрхшээл байна гэж та үзэж байна вэ?
- Олон улсын гэрээг соёрхон батлах явцад парламент ямар хэмжээнд мониторинг хийдэг вэ?
 - Хэрэв нэг эсхүл хоёр гэрээнд гарын үсэг зураагүй/ соёрхон батлаагүй бол ийм эс үйдлийн шалтгааныг тогтоох талаар парламент арга хэмжээ авсан үү? Нөгөө талаар, гарын үсэг зурах явц эхэлсэн бол гэрээний тодорхой заалтыг түр зогсоох санал засгийн газарт байгаа эсэх талаар парламентад мэдээлэл хийсэн үү?
 - Хэрэгжиж буй гэрээний хувьд засгийн газраас илэрхийлсэн түр зогсоох санал нь шаардлагатай хэвээр байгаа эсэхийг парламент хэлэлцсэн үү? Хэрэв тийм бол, түр зогсоох саналаас татгалзах талаар ямар нэг алхам хийсэн үү? Түр зогсоох саналтай холбоотой дүгнэлт ажиглалтын талаар энэ нөхцөлд авч хэлэлцсэн үү?

Асуулт 4: Парламентын үйл ажиллагаанд хүний эрхийн асуудлыг тусгах

Парламентын үйл ажиллагаа нь улс төр, иргэний, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийн бүхий л салбарт нөлөөлдөг. Тиймээс, парламент үйл ажиллагаа, дүрэм журам болон бүтцийнх нь гол төвд хүний эрхийн асуудал байх явдалд анхаарах нь маш чухал. Хүний эрхийн асуудлыг тусгайлан хариуцсан үр дүнтэй ажиллагаа бүхий парламентын хороотой байх нь сайн эхлэл болно. Ингэснээр парламент хүний эрхийн асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч буйг илэрхийлэх бөгөөд хүний эрхийн асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тогтмол оруулах болно. Ийм хороо нь гадны хүний эрхийн түнш байгууллагуудтай харилцах гол этгээд байх бөгөөд парламентын бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийн асуудал тусгалаа олох гол платформын үүргийг гүйцэтгэнэ.

А хэсэг: Суурь түвшингээ тодорхойлох

- Парламентын дотоод бүтцэд хүний эрхийн талаар үүрэг хариуцлагыг тодорхой оногдуулсан уу?
 - Парламентад хүний эрхийн асуудлаарх үүрэг хариуцлагыг хэрхэн оногдуулсан бэ? Хүний эрхийн асуудлыг дагнан хариуцсан парламентын хороог байгуулсан уу? Энэ үүрэг хариуцлагыг парламентын хэд хэдэн хороонд хариуцуулсан уу? Эсхүл энэ үүргийг парламентын аль ч хороонд хариуцуулаагүй юу?
 - Парламентын нэг юм уу түүнээс олон байгууллага/ нэгжид энэ үүргийг хариуцуулсан бол нийт парламентын хэмжээнд хүний эрхийн асуудлаарх үйл ажиллагааны уялдааг хангасан уу? Хэрэв тийм бол яг хэрхэн хангаж, зохицуулсан бэ?
- Парламентад асуудал тусгайлан хариуцсан хороо⁴⁹ хэрэв байдаг бол:
 - Хорооны бүрэлдэхүүн олон ургальч байдлыг хангах, намын харьяаллыг үл харгалзах, жендэрийн тэгш байдлын зарчмыг баримталдаг уу?
 - Хороо нь хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн гишүүдээс бүрддэг үү?
 - Хороо хүний эрхийн асуудлаар хууль тогтоох ба хяналт тавих чиг үүргийг багтаасан өргөн хүрээний эрх мэдэлтэй юу?
 - Парламент тус хороог үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай төсөв санхүү тусгадаг уу?
 - Хороо нь хуулийн төсөл, бусад хууль тогтоомж нь үндэсний болон олон улсын хүний эрхийн асуудлаар тухайн улсын хүлээсэн үүрэг хариуцлагад нийцсэн эсэхийг хянаж дүгнэх боломжтой юу?
 - Хороо нь шаардлагатай гэж үзсэн хүний эрхийн асуудлаар холбогдох хуулийн төсөл боловсруулах, бусад санаачлагыг

49 Парламентын хүний эрхийн хорооны талаар илүү мэдээлэл, зааврыг A/HRC/38/25.Хавсралт 1-ээс харна уу

гаргах мөн хүний эрхийн асуудал, тулгарч буй бэрхшээлийн талаар гуравдагч этгээдээс илэрхийлсэн асуудлыг шийдвэрлэх чадамжтай юу?

- Хороо нь хүний эрхийн асуудлаар парламентын бусад нэгж/байгууллагад зөвлөх эрхтэй юу?
- Хороо нь мэдээлэл хүсэх, гэрчээс мэдүүлэг авах, газар дээр нь очиж ажиллах ажлын хэсэг байгуулах боломжтой юу?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламент хүний эрхийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан уу? Парламентад ХЭҮК болон хүний эрхийн бусад байгууллагаас мэдээлэл хийсэн үү?
- Хороо нь хүний эрхийн асуудлаар тайлан нийтэлж хэвлүүлсэн үү?
- Ямар хороо нь хүний эрхийн асуудлыг шууд авч хэлэлцсэн бэ?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Хэрэв хүний эрхийн асуудлыг дагнан хариуцсан парламентын хороо байдаг бол А хэсгийн эрх мэдлийг хэр түвшинд хэрэгжүүлдэг вэ? Хэрэв дурдсан бүх эрх мэдлийг эдэлдэггүй бол олгогдоогүй байгаа эрх мэдлийг нэмж, бэхжүүлэх боломжийн талаар судалж, ажилласан уу? Олон ургальч байдал, намын харьяаллыг үл харгалзах, жендэрийн тэгш байдлын зарчмыг хангах талаар хороо цаашид ямар арга хэмжээ авах боломжтой вэ? Хорооны гишүүд хүний эрхийн асуудлаар мэргэших талаар?
- Хүний эрхийн асуудлыг хариуцсан хороо байхгүй бол парламентын зүгээс олон улсын болон бүс нутгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх явдлыг дэмжих, хянах зэрэг хүний эрхийн талаарх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулах байнгын хороог байгуулах талаар авч үзсэн үү?
 - Хэрэв тийм бол, хороог байгуулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан уу? Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд парламент өөр ямар арга хэмжээ авсан бэ?
 - Хэрэв үгүй бол, парламентыг ийм хороог байгуулахад юу саад болж байна вэ?
- Парламентын хүний эрхийн хороо нь иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага, бусад холбогдох талуудтай хэр үр дүнтэй хамтарч ажилладаг вэ?
 - Эдгээр байгууллагуудтай парламент ажил хэргийн холбоотой байдаг уу? Хэрэв тийм бол, улс орны хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх зорилгоор эдгээр байгууллагууд нийтийн сонголд уригдан оролцдог уу?
 - Хороо парламент болон бусад хороодын хүрээнд хүний эрхийн талаар мэдээлэл солилцохдоо эдгээр байгууллагуудаас өгөх мэдээлэлд найддаг уу?

Асуулт 5: Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн үйл явцад Хүний эрхийн зөвлөлөөс батлан гаргасан зөвлөмжийн ихэнхид нь парламентаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон түүний оролцоо шаардлагатай байдаг гэсэн судалгаа байдаг.⁵⁰ НҮБ-ын гэрээний байгууллагуудын зүгээс улс орнуудад зориулан гаргасан дүгнэлт ажиглалтыг хэрэгжүүлэхэд болон эрх бүхий тусгай төлөөлөгчийн гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мөн адил парламентын оролцоо шаардлагатай. Хүний эрхийн зөвлөл болон бусад гэрээний байгууллагуудад тайлагнах журамд ижил төстэй талууд байх ба энэ нь гурван үе шаттай байна. Парламент НҮБ-д өргөн мэдүүлэх тайлан боловсруулахад оролцох, эдгээр тайланг танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох, үйл явцын төгсгөлд гарсан зөвлөмжийн талаар мэдээлэл авах зэргээр энэхүү тайлагнах журмын гурван үе шат бүрт тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн парламент урилгыг хүлээн авч дүгнэх, ирж ажиллах бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллах, эргэх холбоотой байх зэргээр НҮБ-ын эрх бүхий тусгай төлөөлөгчидтэй хамтран ажиллана. НҮБ-ын хүний эрхийн механизм нь бүгдийг ижил тэгш хамруулсан, зохицуулалттай байх явдлыг хангах зорилгоор тайлагнах болон зөвлөмж хэрэгжүүлэх талаар олон орон үндэсний хэмжээний механизмыг санаачлан, байгуулаад байна. Парламентын хувьд үйл ажиллагаагаа үндэсний тайлагнах, зөвлөмж хэрэгжүүлэх механизмтай нягт уялдуулах нь чухал.

А хэсэг: Суурь түвшингээ тогтоох

- Парламент НҮБ-ын хүний эрхийн мониторингийн механизмын талаар тогтмол арга хэмжээ авч, үйл ажиллагаанд хувь нэмэр оруулдаг уу?
 - Парламентад тухайн улс ба НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны статусыг баталгаажуулах механизм байгаа юу? (түхэйлбал, парламентын хүний эрхийн хороо, эсхүл хүний эрхийн асуудлаар байгуулагдсан ажлын хэсэг, парламентын бүлэг, тусгай комисс)

- НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаар парламентад байнга мэдээлэл өгдөг үү? Парламентын ажлын албаны ажилтнууд, ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох мэдээллийг тогтмол авах боломжтой байдаг үү?
- Парламент эсхүл эрх бүхий хороо улс орны хүний эрхийн тайланг боловсруулахад оролцдог үү?
- Хүний эрхийн гэрээний байгууллагуудад улс орны өргөн мэдүүлэх үндэсний тайлантай холбоотой тайлагнах хуваарийн талаар парламентын гишүүд мэддэг үү?
- НҮБ-аас ирж ажиллах эрх бүхий тусгай төлөөлөгч нь парламент болон парламентын асуудал хариуцсан хороотой уулзалт хийдэг үү? Парламент тэдгээрийн тайлангийн хувийг системтэйгээр авч танилцдаг үү? Эрх бүхий тусгай төлөөлөгч засгийн газартай харилцсан талаарх мэдээллийн хувийг парламентад өгдөг үү?
- НҮБ-ын хүний эрхийн нэг юм үү түүнээс олон байгууллагад танилцуулах үндэсний тайланг боловсруулж буй ажлын хэсгийн бүрэлдэхүүнд парламентын гишүүд ордог үү?
 - Хүний эрхийн зөвлөл, НҮБ-ын гэрээний байгууллагуудаас гаргасан зөвлөмж, дүгнэлт ажиглалтыг хэрэгжүүлэхэд парламентын гишүүд оролцохыг дэмждэг үү?

Сүүлийн 24 сарын хугацаанд:⁵¹

- Олон улсын хүний эрхийн байгууллагад хүргүүлэх үндэсний тайлангийн төсөл болон тайлангийн эцсийн хувилбарыг хэлэлцэх тусгай чуулганыг парламент зохион байгуулсан үү?
- Парламентын хэдэн гишүүн тухайн тайланг НҮБ-ын механизмд танилцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтсан бэ?
- Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлт ажиглалтыг парламент авч хэлэлцсэн үү? Хэрэв тийм бол, парламентын зүгээс засгийн газар тэдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх талаарх төлөвлөгөөг танилцуулахыг хүссэн үү?
- Эрх бүхий тусгай төлөөлөгчийн зүгээс засгийн газартай хэрхэн харилцсан талаарх мэдээллийг парламент авч хэлэлцсэн үү?

51 24 сарын хугацаа (бусад хэсэгт 12 сар гэж байгаа боловч) нь Нэгдсэн Үндэстний байгууллагын мониторингийн байгууллагын тайлангийн үрт, хэмжээтэй харьцуулахад илүү бодитой хугацаа

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламент олон улсын хүний эрхийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зэргээр НҮБ-ын хүний эрхийн механизмд хэр үр дүнтэйгээр хувь нэмэр оруулсан бэ?
 - НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын гаргасан, ялангуяа тухайн улс орны нөхцөл байдлын талаар гаргасан зөвлөмжийн талаар хэлэлцэх тусгай чуулганыг Парламент зохион байгуулсан үү? Хэрэв тийм бол, ХЭҮК болон иргэний нийгмийн байгууллагуудыг энэхүү чуулганд урьж оролцуулсан үү? Үндэсний тайланг боловсруулах ажилд Парламент оролцсон бол энэ оролцоо нь ямар хувь нэмэртэй байсан бэ?
 - Хэрэв гэрээний байгууллагад хүргүүлэх тайлангийн хугацаа хэтэрсэн бол, тайланг боловсруулж, хүргүүлэх талаар парламент засгийн газарт шаардлага тавьсан үү? Засгийн газрыг тайлагнах үүргээ биелүүлэхийг шаардахад парламентын үйл ажиллагааны журмыг ашигласан үү?
 - НҮБ-ын эрх бүхий тусгай төлөөлөгчөөс тус улсад ирж ажиллах урилгыг хүргүүлэх талаар парламентын зүгээс тодорхой алхам хийсэн үү? Эдгээр байгууллагуудаас тус улсад ирж ажиллах талаар ирсэн хүсэлтэд хариу өгөөгүй байгаа бол энэ талаар парламент мэдээлэлтэй байгаа юу?
- Парламент Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн үйл явцад (дүгнэлтийн өмнө, явцын дунд болон дараа) хэрхэн үр дүнтэй оролцсон бэ?
 - Парламент Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн тайлан боловсруулах Ажлын хэсгийн ажлын явц, зохион байгуулсан хэлэлцүүлэг, үр дүнгийн талаар мэдээлэл өгөхийг засгийн газраас хүссэн үү?
 - Парламент Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хууль тогтоох болон төсөв санхүү шаардлагатай ажлыг хэрэгжүүлсэн үү? Хэрэв тийм бол, энэ ажилд хэрхэн хяналт тавьсан бэ? Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн зөвлөмжийн тодорхой сэдвүүдээр багцалсан матрицийг ашигласан үү?
 - Парламент Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (UPR)-ийн зөвлөмжийн талаар (ялангуяа хүлээн зөвшөөрсөн зөвлөмж) тогтмол мэдээлэх, эсхүл хэрэгжилтийн явцад дунд хугацааны тайланг танилцуулахыг засгийн газраас хүсч, тайланг боловсруулахад (парламентын хүний эрхийн хороогоор дамжуулан) идэвхтэй оролцсон үү?
- Үндэсний тайланг боловсруулах явцад парламент засгийн газартай нээлттэй хэлэлцэж, тайлан гаргахад хувь нэмрээ оруулсан үү?
 - Үндэсний тайланг боловсруулах явцад парламент засгийн газрыг эхний алхам болгож өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулахыг уриалж, ингэхдээ өмнөх дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд анхаарахыг зөвлөсөн үү?
 - Парламентын зүгээс тайлан боловсруулахдаа зөвлөлдөх үйл явцын хүрээнд ХЭҮК, ТББ, ИНБ зэрэг холбогдох байгууллагуудаас гаргасан мэдээллийг бүрэн авч үзэж, тусгах талаар засгийн газрыг дэмжиж ажилласан үү?
- НҮБ-ын хүний эрхийн механизмд тайлангаа танилцуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд парламентын гишүүн ороогүй бол, парламент энэ асуудлыг шийдэх талаар санал гаргасан үү?

Асуулт 6: Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн зорилго 2030 хоорондын уялдааг хангах

Хүний эрхийн асуудал нь Тогтвортой хөгжлийн зорилго 2030-ыг дэлхий нийтээр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бүрэн тусгалаа олсон. ТХЗ-уудын 92 хувиас илүү нь олон улсын хүний эрхийн талаарх тодорхой заалтуудыг тусгасан байдаг⁵³. Учир нь тогтвортой хөгжлийн 17 зорилго нь “бүх хүмүүсийн хүний эрхийг хангахыг зорьдог” тул хүний эрх болон ТХЗ-ийн хоорондын уялдааг хангах замаар аль аль нь бүрэн хэрэгжих боломжтой бөгөөд тэдгээр нь хоорондоо салшгүй харилцан хамааралтай юм. Хүний эрх ба ТХЗ хоорондын харилцан холбооны талаар парламентын гишүүд мэдэж байх хэрэгтэй бөгөөд ТХЗ 2030-ыг хэрэгжүүлэхдээ олон улсын хүний эрхийн зөвлөмжийг харгалзах, мөн хүнийг эрхийг хэрэгжүүлэхдээ ТХЗ-уудтай уялдуулах стратегийг эрэлхийлэх шаардлагатай⁵³.

А хэсэг: Суурь түвшингээ тодорхойлох

- 2030 зорилго, хүний эрхийн асуудалтай хэрхэн холбогдох талаарх мэдээлэл парламентын гишүүдэд нээлттэй байна уу?
- 2030-зорилгуудын хэрэгжилтэд мониторинг хийх үүрэг бүхий парламентын хороо байдаг уу? Хэрэв тийм бол, энэ хороо нь парламентын бусад хороотой (хэрэв байдаг бол, ялангуяа, хүний эрхийн асуудал хариуцсан хороотой) хамтарч ажилладаг уу?
- Парламент ТХЗ-ийн ерөнхий тогтолцоог хүний эрхийн өнцгөөс хэлэлцэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан уу? Хэрэв тийм бол, 2030 зорилгын “хэнийг ч орхихгүй тэгш хамруулах” хандлагыг анхааралтай авч үзсэн үү?
- Парламентын гишүүдийг ТХЗ-уудыг хэлэлцэх олон улсын болон бүс нутгийн семинар/ уулзалтад оролцох, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмд мөн оролцохыг дэмждэг үү?

52 Дани Улсын хүний эрхийн институтаас гаргасан тоо мэдээлэл. Дани Улсын хүний эрхийн институт: “Хүний эрхийн гарын авлага ба Тогтвортой хөгжлийн зорилтууд” <https://sdg.humanrights.dk/>.

53 Парламентын гишүүд ТХЗ ба хүний эрхийн асуудлын хоорондын холбоог ОУПХ-ны өөртөө хийх үнэлгээний аргачлалаас харж болно. ОУПХ: Парламент ба Тогтвортой хөгжлийн зорилтууд: Өөртөө үнэлгээ хийх аргачлал.(Женев хот, ОУПХ, 2016) <https://www.ipu.org/file/2549/download>.

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламент хүний эрх болон ТХЗ-ын хоорондын уялдаа холбооны талаар нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулсан уу?
- ТХЗ ба хүний эрхийн асуудлын хоорондын уялдааг хангах талаар аль хорооноос хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан бэ?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламентын ТХЗ-ын асуудлыг хариуцсан хороо (хэрэв байдаг бол) парламентын гишүүд болон парламентын ажлын албаны ажилтнуудыг 2030 зорилтуудын талаарх мэдээллээр хангахад парламентын номын сан хэр үр дүнтэй байна вэ?
- Хэрэв парламентад хүний эрх ба ТХЗ-ын асуудлыг хариуцсан тусгай хороо байдаг бол тус хороо эдгээр зорилтод хүрэхийн тулд салбар дундын зорилт болон стратегийн талаар хэлэлцэх хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулсан уу? Хэр тогтмол уулзаж ярилцдаг вэ?
- ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжих ерөнхий тогтолцоонд хийдэл байгаа эсэхийг парламент дүгнэж үзсэн үү? Энэ тогтолцоо нь хүний эрхэд суурилсан хандлагыг баталгаажуулсан уу?
- Парламент хүний эрх, хөгжил, ТХЗ-уудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдааг сайжруулах зорилгоор ТХЗ болон олон улсын, бүс нутгийн хүний эрхийн механизмын зөвлөмжийн хоорондын хэлхээ холбоог тодорхойлсон уу?

Асуулт 7: Хүний эрхийг хангахад шаардлагатай санхүү, төсвийг баталгаажуулах

Парламент нь хууль тогтоох болон хянан шалгахад гадна улсын төсвийг батлах чиг үүрэгтэй. Хүний эрхийг хангах, хамгаалахад санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байдаг тул хүний эрхийг хэрэгжүүлэхэд төсөв шууд нөлөөлдөг. Иймээс, парламент олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд хүний эрхийн хэм хэмжээ, стандартыг ханган биелүүлэхэд шаардагдах хангалттай санхүүжилтийг тусгаж буй эсэх хүрээнд улсын төсвийг системтэйгээр хянаж байх нь маш чухал.

А хэсэг: Суурь түвшингээ тодорхойлох

- Парламент хүний эрхийг сахин хамгаалах нөхцөлийг хангах талаас нь төсвийн саналыг хянаж үзсэн үү? Үүнтэй адил, улсын төсөвт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх талаар санхүүжилт тусгагдаж буй эсэхийг харах боломжтой байдлаар төсвийн төслийг боловсруулсан байна үү? Улсын төсөвт олон улсын хүний эрхийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой санхүүжилтийг тусгасан байна үү?
- Парламент улсын төсвийн зарцуулалтыг хянахдаа хүний эрхийг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийг үр ашигтай, үр дүнтэй ашигласан эсэхийг үнэлдэг үү? Түүнчлэн төсвийн нийт зарцуулалт нь хүний эрхийн асуудалд үзүүлсэн эцсийн үр нөлөө ямар байсан бэ? Парламент улсын аудитын дээд байгууллага (ҮАГ) болон ижил төстэй байгууллагын тайланг хэлэлцсэн үү?
- Парламент ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан төсөв батлагдахаас өмнө сонсгол зохион байгуулдаг үү?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламентын холбогдох хороодын хэдэн тайланд хүний эрхтэй холбоотой төсөв санхүү, зарцуулалтын талаар тодорхой тусгасан байсан бэ?
- Парламент улсын төсөв батлах үйл явцад хүний эрх ба ТХЗ-уудын хоорондын холбоо, хамаарлын асуудлыг тусгасан үү?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламент улсын төсвийг батлахдаа хүний эрхийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв санхүүг тусгах чиглэлээр хэр зэрэг үр дүнтэй ажилласан бэ?
 - Парламент ХЭҮК зэрэг хүний эрхийн дэд бүтцэд хангалттай санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусгаж чадсан уу?
 - Парламент төсөв жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн тэгш байдлыг хангасан байх нөхцөлийг бүрдүүлж чадсан уу?
 - Парламент алагчилах байдлыг хэвээр байлгах бус харин шийдвэрлэхэд чиглэсэн төсвийг баталж чадсан уу?
 - Хүний эрхийг хангахад хангалттай төсөв байхгүй тохиолдолд парламент эсхүл холбогдох хороод засгийн газрыг шаардлагатай өөрчлөлт оруулах талаар санал гаргаж, ажиллах талаар шаардлага тавьсан уу?
- Парламент олон улсын хүний эрхийн талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэх явдалд ахиц гаргахад дэмжлэг болж буй эсэхийг үнэлэх зорилгоор төсвийн зарцуулалтад хэр зэрэг үр дүнтэй хяналт тавьж ажилласан бэ?
- Хэрэв ингэж ажиллаж хэвшээгүй бол, Аудитын ерөнхий газрын тайланд хүний эрхийн асуудлыг хангалттай авч үзэх нөхцөлийг бүрдүүлэх талаар парламент ямар арга хэмжээ авсан бэ?
- Төсвийн үйл явцад иргэдийн үр дүнтэй оролцоог хангах зорилгоор төсөв батлагдахаас өмнө төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг парламент дэмжин ажиллаж чадсан уу?

Асуулт 8: Олон нийт болон хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх

Идэвхтэй үйл ажиллагаатай парламент нь хүний эрхийн асуудлаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдний дуу хоолойг сонсох үйл явцыг дэмжиж ажилладаг. Парламентын гишүүд төлөөлөл болж сонгогдсон байр сууриа ашиглан олон нийттэй харилцан нийгмийн хэмжээнд хүний эрхийн тулгамдсан асуудлыг ойлгох, хүний эрхийн талаарх гол зөвлөмжүүд бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж буйг үнэлэх боломжтой байна. Хүний эрхийн чиглэлээр мэргэжлийн чухал эх сурвалж болох ХЭҮК болон иргэний нийгэмтэй түншилж ажиллах нь (хүний эрхийн хороогоор дамжуулах зэргээр) парламентад ихээхэн үр ашигтай байна.

А хэсэг: Суурь түвшингээ тодорхойлох

- Парламент хүний эрхийн асуудлаар олон нийтийн арга хэмжээ зохион байгуулдаг уу? (тухайлбал, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт – UPR болон гэрээний байгууллагын дүгнэлтээс өмнө)
- Парламентын гишүүд өөрсдийн тойрогтоо хүний эрхийн асуудлыг хөндөж тавьдаг уу?
- Парламент ХЭҮК-ийн тайланг авч хэлэлцдэг үү?
- Парламент иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол харилцдаг болон/ эсхүл тэдний саналыг сонсдог уу?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Хүний эрхийн асуудлаар нийтийн сонголт парламентаас санаачлан эсхүл парламентын хэмжээнд зохион байгуулсан уу?
- Тойрогтоо хүний эрхийн асуудлаар ажилласан уу?

В хэсэг: Хийж гүйцэтгэсэн ажлын үр нөлөөний талаар ярилцах

- Парламент үндэсний болон олон улсын хэмжээнд хүний эрхийг дэмжих чиглэлд хийж гүйцэтгэсэн ажлын талаар олон нийтэд мэдээлэх талаар хэр зэрэг үр дүнтэй ажилласан бэ?
 - Парламент хүний эрхийн асуудлаар олон нийтэд ойлголт, мэдлэг түгээх зорилгоор орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулах кампанит ажил, хэлэлцүүлэг, семинар, үулзалт зохион байгуулах зэрэг асуудлыг тусгасан олон нийттэй харилцах стратегийг баталсан уу?
 - Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр тохиодог Хүний эрхийн олон улсын өдрөөр үг асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах талаар Парламент хэрхэн ажилласан бэ? Бусад тэмдэглэлт өдрүүдийг (Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдөр гэх мэт) эрх ашиг нь хөндөгдөж буй бүлгүүдийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор ашигладаг уу?
 - Хүний эрхийн талаар соёрхон баталсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт протоколын талаарх мэдээллийг парламентын вэб хуудаснаас олж авахад хялбар байдаг уу?
- Парламентын гишүүд өөрсдийн тойрогтоо хүний эрхийн асуудлаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх талаар хэр зэрэг үр дүнтэй ажилласан бэ?
 - Парламентын гишүүд хүний эрхийн асуудлаар телевиз, радиогийн хэлэлцүүлэг, олон нийтийн үулзалтад оролцдог, эсхүл энэ асуудлаар ярилцлага өгдөг үү?
 - Парламентын гишүүд олон нийтэд нээлттэй сонин, сэтгүүлд хүний эрхийн талаар нийтлэл бичиж хэвлүүлдэг үү?
 - Парламентын гишүүдийг ийм арга хэмжээнд оролцохыг парламентын удирдлагын зүгээс дэмжиж уриалдаг уу?
- Парламент ХЭҮК-той системтэйгээр хамтарч ажилладаг уу? Хэрэв тийм бол, хэрхэн ажилладаг вэ? Парламент ХЭҮК-ийн тайлан болон өргөн мэдүүлсэн бусад мэдээллийг хэр зэрэг үр дүнтэй хэлэлцдэг вэ? ХЭҮК-ийг чуулганд тайлангаа танилцуулахыг урьж оролцуулдаг уу? Эдгээр тайлангийн талаар хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлдэг үү? Парламент ХЭҮК-оос гаргасан зөвлөмж, дүгнэлтийн ихэнхийг, бүгдийг биш бол, хүлээн авдаг уу?
- Парламент хүний эрхийн асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудтай хэр түвшинд хамтарч ажилладаг вэ?
 - Парламент тодорхой асуудлаар ИНБ-ын мэргэжлийн үзэл бодлыг системтэйгээр авч үздэг үү? Үүнд тогтсон ялгаварлан гадуурхалтад өртөж буй эмзэг бүлэгт хүрч ажиллах асуудал багтдаг уу?
 - Парламент санаачилж буй хууль тогтоомжийн төсөл, хэлэлцүүлгийн талаар мэдээлэх зэргээр үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэдэг үү?
 - Парламентын сонсгол, хороодын сонсгол нь биечлэн оролцох эсхүл телевиз болон бусад мэдээллийн сувгаар иргэний нийгэм, олон нийтэд нээлттэй явагддаг уу?
 - ИНБ парламентын тодорхой хороодод бичгээр болон амаар саналаа хүргүүлэх боломж олгодог журам, үйл явдлыг хэвшүүлэхийн тулд парламент өөр юу хийж болох вэ?

Ном зүй

Хүний эрх

- Олон Улсын Парламентын холбоо (ОУПХ) (2014), Парламентад дэмжлэг үзүүлэх зарчим, Женев хот, ОУПХ https://archive.ipu.org/pdf/publications/principles_en_pdf
- ОУПХ (2016), Парламентын жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлэх нь: өөрийн үнэлгээний аргачлал. Женев хот: ОУПХ <https://archive.ipu.org/pdf/publications/gender-toolkit-e.pdf>.
- ОУПХ ба НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (2016) Хүний эрх: Парламентчдад зориулсан гарын авлага №26, Женев хот. ОУПХ ба НҮБХЭДКГ <https://www.ohchr.org/sites/default/files/Documents/Publications/HandbookParliamentarians.pdf>
- НҮБХЭДКГ (2015) Дэлхий ертөнцөө өөрчилье: Тогтвортой хөгжлийн зорилго 2030 дахь хүний эрх. Женев хот, НҮБХЭДКГ <https://www.ohchr.org/Documents/Issues/MDGs/Post2015/TransformingOurWorld.pdf>.
- НҮБХЭДКГ ба Олон улсын төсвийн түншлэл (2017), Засгийн газрын төсвөөр дамжуулан хүний эрхийг хэрэгжүүлэх нь. Нью Йорк, Женев хот: НҮБХЭДКГ <https://www.ohchr.org/Documents/Publications/RealizingHRThroughGovernmentBudgets.pdf>.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2012), Хүний эрхийн үндэсний байгууллага ба парламент хоорондын харилцааны зарчмын талаарх Белградын Тунхаг A/HRC/20/9 <https://undocs.org/en/A/HRC/20/9>

Парламент ба НҮБ

- НҮБХЭДКГ, “Үндэсний хэмжээний байгууллагын статустай холбоотой зарчмууд (Парисын тунхаг)”: 1993 оны 12-р сарын 20-ны өдөр баталсан <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/statusofnationalinstitutions.aspx>
- НҮБ-ын Ерөнхий Ассемблей (2017), Олон улсын хамтын ажиллагааг сайжруулах замаар хүний эрхийн салбар дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх ба аль нэг талыг барьж сонгохгүй, төвийг сахих, нөлөөнд автахгүй байхын чухал болох нь A/72/351 <https://undocs.org/en/A/72/351>.

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Парламент ба UPR <https://www.ohchr.org/EN/HRBodies/UPR/Pages/Parliaments.aspx>
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2007), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн байгууллагыг бэхжүүлэх нь A/HRC/RES/5/1. https://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/RES/5/1
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2017), 2013 оны 6-р сарын 23-ний өдөр Хүний эрхийн зөвлөлийн баталсан тогтоол. Хүний эрхийн зөвлөл болон Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит дүгнэлтийн үйл ажиллагаанд парламентын оруулах хувь нэмэр A/HRC/ RES/35/29. <https://undocs.org/en/A/HRC/RES/35/29>
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2018), Хүний эрхийн зөвлөл болон Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит дүгнэлтийн үйл ажиллагаанд парламентын оруулах хувь нэмэр. НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын тайлан A/HRC/38/25. <https://undocs.org/en/A/HRC/38/25>
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2019), Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, бэхжүүлэх нь. A/ HRC/41/25. <https://undocs.org/en/A/HRC/41/25>
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (2019), Хүний эрх, Ардчилал, Хууль дээдлэх ёсны форумын Хоёр дахь чуулган A/HRC/40/65. <https://undocs.org/en/A/HRC/40/65>

Парламент ба ТХЗ-үүд

- ОУПХ (вэб хуудас) www.ipu.org
- ОУПХ (2016) Парламент ба Тогтвортой хөгжлийн зорилгууд: Өөрийн үнэлгээний аргачлал. Женев хот: ОУПХ. <https://www.ipu.org/file/2549/download>
- Дани Улсын Хүний эрхийн институт (вэб хуудас): <https://sdgdata.humanrights.dk/>



Inter-Parliamentary Union
For democracy. For everyone.

T +41 22 919 41 50
F +41 22 919 41 60
E postbox@ipu.org

Chemin du Pommier 5
Case postale 330
1218 Le Grand-Saconnex
Geneva – Switzerland
www.ipu.org



T +41 22 917 92 20
E ohchr-infodesk@un.org

Office of the United Nations
High Commissioner for Human
Rights (OHCHR)
Palais des Nations
1211 Geneva 10, Switzerland
www.ohchr.org